

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР	УЛС ТӨР ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ХЭРЭГЖИЖ, БАРИВЧЛАХ ЯЛТАЙ ХҮМҮҮЖИГЧДИЙГ СУЛЛАЛАА II нүүрт	УЛС ТӨР ЭРДЭНЭГИЙН АР ДАХЬ НУУЦ ТАЙЛАГДЛАА V нүүрт
------------------------------	---	--

Дугаарын **60** мөр

МУБИС үнэд орох цагаар...

Г.ГАНЧИМЭГ

Ойрын өдрүүдэд Монголын ард түмэн сонгууль, сонголтоор амьсгалж байна. Эхнийх нь Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгчөөрөө хэн гэдэг эрхэмийг сонгох вэ гэдэг түүхэн сонголт буюу улс төрийн сонгуульд Монгол Улсын иргэн бүр оролцоно. Харин нөгөө нь энэ жил 12 дугаар ангич төгсч, алдрай насаа үдэн амьдрал хэмээх их далайд хөл тавьж буй охид хөвгүүдийнхээ мэргэжлийг сонгох их ажил яг энэ цаг үед өрнөж байгаа. Сонгуулиас ч дутахааргүй ач холбогдолтой мэргэжил сонголт тухай яриа төгсөх ангийн хүүхэдтэй айл болгоны гал тогооны халуун сэдэв болж буй. Төгсөөд ажлын байр хэр олдоцтой вэ, тэтгэлэгт хамрагдаж болох уу гэх мэтээр орчин үеийн залуус илүү бодитой, амьдралд ойр асуултууд тавьж, сонгосон мэргэжлээ нухацтай судлан аав ээж, багштайгаа зөвлөж шийддэг болжээ. Ажиглаад байхад, хот хөдөөгүй хамгийн эрэлттэй, хэзээд хүний нөөц нь дүүрдэггүй мэргэжил бол багш юм байна.

Хаана ч очсон ажлын байртайгаа, бас ч гэж цалин хангамж сайтай, нийгмийн асуудлуудыг нь шийдвэрлэхийн тулд төрийн болон төрийн бус байгууллагуудын олон төсөл, хөтөлбөр хэрэгждэг боломжийн салбар учраас тэр биз. Хамгийн гол нь нэгэнт сонгосон мэргэжлээ сайн сургуульд чанартай эзэмшвэл зорилгоо биелүүлж, мөрөөдөлдөө хүрэх эхний алхамаа хийж буй нь тэр. МУБИС яг энэ шалгуурт тэнцэнэ гэдэгтэй маргах хүн цөөн биз.

Үргэлжлэл нь III нүүрт

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ


Хүчиндүүлсэн хүн нь нэр төрд халдсан болж, давхар хохирох нь гэв



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

УИХ-ын гишүүн хүчингийн хэрэг үйлдсэн талаар дам мэдээлэл социал ертөнцөд тарсан. Сүүлдээ хүчингийн хэрэг үйлдсэн хүн нь УИХ-ын залуу гишүүн хэмээх мэдээлэл тарж,

хэрэгт холбогдсон эрхэм өөрөө үгүйсгэж байсан. Тэгвэл өнөөдөр УИХ-ын гишүүнд хүчиндүүлсэн гэх хохирогчийн эгч болон хүний эрхийн хуульч М.Ичинноров нар хэвлэлийнхэнд хандлаа. Мэдээлэл технологийн үндэсний паркийн гадаа болсон хурлын эхэнд хүний эрхийн хуульч М.Ичинноров "Хүний эрхийн ноцтой зөрчлийн талаар мэдээлэл өгөхөөр ирлээ. Энэ оны зургадугаар сарын 12-ны өдөр УИХ-ын гишүүн Гантулга 25 настай оюутан охиныг өөрийнх нь гэрт хүчиндсэн хэрэг болсон. Энэ хэргийг шалгуулах хугацаанд тэд цагдаа, хүчний байгууллага, шүүхийг бүгдийг нь худалдаж авч, өөрсдийнхөө талд ажиллуулсан. Үргэлжлэл нь III нүүрт



САЙД ЯРЬЖ БАЙНА

Д.ОЮУНХОРОЛ: Монголыг дэлхийд таниулах аялал жуулчлалын цогцолборын ажлыг эхлүүлээ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхоролтой цаг үеийн асуудлаар ярилцлаа.

"Мянганы суут хүн-их эзэн Чингис хааны" өлгий нутаг болсон Хэнтий аймгийн Дадал суманд түүхэн аялал жуулчлалын цогцолбор байгуулах шилдэг санааны уралдааныг танай яамнаас зарлаж амжилттай зохион байгууллаа. Өнгөрсөн ням гарагт шилдэг санаа, зураг төсөл бүхий шилдэг 12 баг бүтээлээрээ үзэсгэлэн гаргаж, та бүхэн ялагчийг тодруулсан

үйл явдал болсон. Энэ талаар ярилцлагаа эхэлбэ? -НУБ-аас 2017 оныг "Тогтвортой аялал жуулчлалын жил" болгон зарласан. Энэ жилийн хүрээнд манай яамнаас хийж байгаа ажлуудын нэг нь "Мянганы суут хүн-их эзэн Чингис хааны аялал жуулчлалын цогцолбор"-ыг байгуулах ажлын эхлэлийг тавих явдал байсан. Монголыг дэлхийд таниулах хэмжээний энэ том төслийн санаачилгыг анх УИХ-ын дарга М.Энхболд гаргаж, Засгийн газарт холбогдох чиг үүрэг өгснөөр ийнхүү ажил хэрэг болгох эхлэлийг амжилттай тавилаа. Үргэлжлэл нь II нүүрт

ЖИВХ, "ДАМСК" ИМПОРТЛОГЧДООС УСТГАХ ҮЙЛДВЭР НЭХЭХ ЦАГ БОЛЖЭЭ

Н.ПУНЦАГБОЛД

"Туул голоо аварья" уриан дор нэгдсэн залуус энэ сарын 1-ний өдөр Туул гол орчмын хогийг цэвэрлэж байгаа талаар мэдээлэл социал ертөнцөд тарсан. Цэвэрлэгээнд 120 гаруй залуу оролцож, Туул голынхоо хогийг цэвэрлэсэн юм. Тэр мэдээллийн зургийг нь уншигч авхай та анзаарсан байх. Туул голоор дүүрэн гялгар уут, цаасан хаягдал, цаашлаад хүүхдийн живх, эмэгтэй хүний ариун цэврийн хэрэглэл буюу "дамск" байх жишээтэй. Мөн хүүхдийн живх, ариун цэврийн хэрэглэлийг бөөгнүүлээд ой модонд хаячихсан зураг фэйсбүүк хуудсаар "явж" байсныг ч хүмүүс харсан л байх. Хөдөө гадаа явахад хаа сайгүй тааралддаг зүйлийн

нэг нь хүүхдийн живх. Хүмүүс хүүхдийнхээ живхийг солиод, шууд л байгальд хаячихдаг. Эмэгтэйчүүдийн ариун цэврийн хэрэглэлийг ч энд мартаж болохгүй. Хамгийн гол нь эдгээр бүтээгдэхүүнд хог гэхээсээ илүүтэй байгальд онц аюул учруулдаг гэдгийг л анхааруулах гээд байгаа юм. Хүүхдийн живх, эмэгтэйчүүдийн ариун цэврийн хэрэглэл, нойтон салфетка зэрэг бүтээгдэхүүнүүд 100 жил болж байж байгальд шингэж, устаж алга болдог гэж байгаа. Монголд "Макс", "Таванбогд", "Номин", "Анунгоо", "MSM" зэрэг томоохон компаниуд хүүхдийн живх гаднаас оруулж ирж, худалдаж байна. Бас цөөн хэдэн үндэсний үйлдвэрлэгчид живх үйлдвэрлэж эхэлсэн юм билээ. Үргэлжлэл нь III нүүрт

19 ДЭХ ЖИЛДЭЭ

МОНГОЛЫН МЭДЭЭ

Манай сонины III улирлын захиалга үргэлжилж байна

Улиралд **44** дугаар

Захиалгын үнэ 19800

Монгол шуудан: 70078977
 УБ шуудан: 70127027
 Скай post: 70121294
 Түгээмэл шуудан: 70115025

ХААН Банк				Худалгаа хөгжлийн банк				
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2352.00	2366.00	ФУНТ	3019.00	3111.00	АМ.ДОЛЛАР	2345.00	2365.00
ЕВРО	2657.00	2708.00	РУБЛЬ	39.00	40.90	ЕВРО	2650.00	2722.00
ИЕН	20.77	21.07	ЮАНЬ	345.80	348.80	ИЕН	20.66	21.26
						ФУНТ	3018.00	3100.00
						РУБЛЬ	38.86	41.79
						ЮАНЬ	345.00	349.20

УЛС ТӨР

БАЙНГЫН ХОРОО



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Д.ЭРДЭНЭБАТ: АН иргэдийг өрийн дарамтнаас гаргах хууль санаачилна

улс төрийн сонгуулийн ирцийг хүргэхгүй байх сонирхолтой байна. Сонгуулийн хүчингүй болгохын тулд иргэдийг буруу зүйлд уриалан дуудсан үйлдлийг АН-ын бүлгийн дэд даргын хувьд буруу гэж үзэж байгаагаа илэрхийлэхийг хүсч байна. Монголын иргэд, сонгогчид долдугаар сарын 7-нд сонгуулиа идэвхтэй оролцож, саналаа баталгаажуулна гэдэгтээ итгэлтэй байна. Өөрийнхөө дотоод үнэмшлээр саналаа өгөөрэй гэж уриалахыг хүсч байна. Нэг сонгууль зохион байгуулахад ойролцоогоор 20 тэрбум төгрөгийн зардал гарна. 20 цэцэрлэг, сургууль барих хэмжээний зардлаар УИХ, Ерөнхийлөгчийн сонгуулийг хийж байна. Цагаан сонгууль өгөөрэй хэмээн уриалж байгаа хүмүүс Монголын татвар төлөгчдийн нуруунд дарамт учруулья гэдэг бодолтой. АН-ын бүлэг иргэдийнхээ өмнө тулгарсан олон асуудлыг шийдэхийн тулд явж байгаа. Тухайлбал, зээлийн дарамтад орсон иргэдийг зээлийн дарамтаас чөлөөлөх бодлого барьж байна. Үүнийг Х.Баттулга гэдэг нэр дэвшигчид хэрэгжүүлж өгөөч гэсэн хүсэлт тавьсан. Энэ талаархи олон улсын жишээ бий. Финлянд улс оюутны зээлээ хаасан. Австрали улс тэтгэврийн зээлээ хааж байсан. Ардчилсан намыг хөтөлбөр гаргах болгонд МАН эсэргүүцдэг. Гэхдээ үнэнд гүйцэгддэг юм” гэлээ.

Ж.Батзандан: 20 цэцэрлэг, сургууль барих мөнгөөр сонгууль зохион байгуулдаг учраас саналаа идэвхтэй өгөөрэй

Мөн хэвлэлийн бага хурлын үеэр УИХ-ын гишүүн Ж.Батзандан “Улс төрийн зарим хүчнүүд долдугаар сарын 7-нд иргэдийг сонгуульд оролцохгүй байхыг уриалсан мэдэгдэл гаргаж байна. Зарим улстөрчид цагаан санал өгөөрэй хэмээн уриалж байна. Монгол Улсын Үндсэн хууль болон Сонгуулийн тухай хуульд иргэдийн санал өгөх эрхт хөндлөнгөөс нөлөөлөх, санал өгөхгүй байхыг уриалах, санал өгөхөд нь тулган шаардах мэдэгдэл хийхийг хуулиар хориглодог. Иргэн хүн ямар намд саналаа өгөхөө дотоод итгэл, үнэмшлээрээ шийдэх эрхтэй. Гэтэл зарим

Нэг тэрбум ам.долларын зээл өрхийн орлогод дарамт учруулж байна

Харин АН-ын гишүүн З.Нарантуяа хэвлэлийн бага хурлын үеэр 2016 оны төсвийн тодотголын талаар мэдээлэв. Тэрбээр “Макро эдийн засгийн тогтвортой байдлыг үнэлдэг 10 гаруй гол үзүүлэлтүүд байдаг. Энэхүү үзүүлэлтээс хоёр нь л өсөлттэй, бусад нь дандаа

Н.БАТЗАЯА

Ардчилсан намын бүлэг ээлжит хуралдаанаа өчигдөр хийлээ. Хуралдаанаар хоёр үндсэн болон бусад дагалдах гурван асуудлыг хэлэлцжээ. Бүлгийн хурлын дараа хэвлэлийн бага хурал зарлаж, сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ. Мэдээллийн эхэнд тус намын дарга Д.Эрдэнэбат өнгөрсөн долоо хоногийн чуулганы хуралдаанаар Монгол Улсын өнгөрсөн нэг жилийн эдийн засгийн өөрчлөлт, төсөвтэй холбоотой үйл ажиллагааг хэлэлцсэнийг онцлов. Мөн Ерөнхийлөгчийн сонгуультай холбогдуулж хэт улстөржиж, нэг талыг барин 2016 оны үйл явдалд АН-ыг буруутгахыг оролдсон чуулган болсон хэмээн дүгнэсэн юм. Энэ талаар УИХ дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Эрдэнэбат “Тоон

үзүүлэлт бол бодит зүйл. 2016 оны зургадугаар сараас 2017 оны тавдугаар сарын хооронд Монгол Улсын нийт өр 22.5 тэрбум ам.доллараас 24.9 болж 2.4 тэрбум доллараар өссөн байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалт 175 сая ам.доллар байсан бол -32.8 сая ам.долларын алдагдалтай болж буурсан байна. Инфляци 1.6-3.7 хувь болж өсчээ. Монголбанкны төгрөгийн ам.доллартай тэнцэх ханш 1964 байсан бол 2413 төгрөгтэй тэнцэж байна. Гадаад валютын албан нөөц 1.4 тэрбум ам.доллар байсан. Харин 2017 оны долдугаар сарын байдлаар 1.23 тэрбум ам.доллар болж буурлаа. Мөн чанаргүй зээлийн хувьд 2016 оны зургадугаар сард нэг их наяд 36 тэрбум төгрөг байсан бол тавдугаар сарын байдлаар нэг их наяд 158 тэрбум төгрөг болж 6.5 хувиар өссөн. Эдийн засгийн өсөлт гаргасан гэдгээ эрх баригчид бодитой хэлээч ээ. Дараагийн асуудал нь Багшийн хөгжлийн тухай хуулиар Ардчилсан нам завсарлага авсан. Сонгуулийн өмнө гэнэтхэн энэ хуулийг МАН-ын зарим гишүүд санаачилж орж ирсэн. Бид үүнийг улс төрийн оноо авах гэж байна гэж үзсэн. Бид хуулийг судлахгүйгээр саналаа өгөх боломжгүй” гэв.

Сонгуулийн амлалт бус АН-ын санаачилга гэв

Мөн энэ сарын 2-нд АН-ын гишүүд Монгол Улсын

Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Х.Баттулгад иргэдийг өрийн дарамтнаас гаргах тухай даалгавар өгсөн билээ. Тодруулбал, тэтгэвэр, цалин сургалтын төлбөрийн болон малчны зээлтэй нийт иргэдийнхээ одоо байгаа зээлийн үлдэгдлийг байгалийн баялгаас иргэдэд хүртээх өгөөж, хувьцааны ногдол ашгаас төлүүлэх даалгавар өгсөн юм. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн 1-д “Монгол Улсад газар түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг холбогдол бүхий орд газрын үр өгөөжөөс иргэдэд шууд хүртээх буюу уул уурхайн салбарын томоохон компаниудын төрийн мэдлийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулж, хувьцаа хэлбэрээр иргэдэд эзэмшүүлж, ногдол ашиг хуваарилах, орлогын тогтвортой эх үүсвэртэй болгохыг хүссэн. Тэгвэл уг асуудалтай холбогдуулан АН-ын дарга Д.Эрдэнэбат хэвлэлийн бага хурлын үеэр мэдээлэл өгөв. Тэрбээр “АН-аас иргэдийг өрийн дарамтаас чөлөөлөх тухай санаачилга гаргасан. Үүнийг үзээд АН-ын бүлэг дэмжиж, хууль санаачлах нь зүйтэй гэж үзэж байна. Ардчилсан нам бүх зүйлд түүчээлэгч нь байж ирсэн. Иргэдийг өрийн дарамтаас чөлөөлөх нь Ардчилсан намын зургаа дахь санаачилга. Энэ

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

Эрүүгийн хууль хэрэгжиж, баривчлах ялтай хүмүүжигчдийг суллалаа

Н.БАТЗАЯА

УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар өнгөрсөн тавдугаар сард Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг, хэлэлцэж баталсан. Уг хуулиар баривчлах ялыг халж, “Ялтай байдал”, “Онц аюултай гэмт хэрэгтэн”, “Давтан” гэх зэргээр хууль зүйн үр дагавар үүсгэж, гэмт хэрэг үйлдсэн хүний эрх зүйн байдлыг дордуулсан зохицуулалтыг хүчингүй болгосон. Мөн цаазаар авах ялыг халж, хорих ялын дээд хэмжээг багасгасан зэрэг олон өөрчлөлт орсон билээ. Тэгвэл энэхүү хууль долдугаар сарын 1-нээс эхлэн хэрэгжиж буй. Хуулийн хэрэгжилттэй холбогдуулан шүүхүүд шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн нийт 4727 ялтны материалыг хянаж байна. Шинэ эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцоггүй болсон үйлдэл, эс үйлдэхүүд ял шийтгүүлсэн этгээдийг эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээнээс чөлөөлөх, оногдуулсан ял нь тухайн төрлийн ялын хэмжээнээс хүнд байвал дүйцүүлэн хасах шийдвэрийг анхан шатны шүүхүүд энэ сарын 3-наас гаргаж эхэлжээ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн материалын 1680



нь нийслэл дэх, 3047 нь орон нутаг дахь хорих ангиудад ял эдэлж буй ялтнуудтай холбоотой бөгөөд улсын хэмжээнд анхан шатны шүүхийн 62 шүүх бүрэлдэхүүн дээрх ялтнуудын материалыг судалж, ялаас чөлөөлөх болон хасах асуудлыг шийдвэрлэж байгаа ажээ. Тухайлбал, ШШГЕГ-ын 431 дүгээр хорих ангиас 52 хүмүүжигчийг баривчлах ялаас чөлөөлжээ. Энэ талаар Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч И.Ганбат “2015 оны шинэчилсэн

найруулсан Эрүүгийн хуулийн 5.2 дугаар зүйлд заасан ялын үндсэн төрөл баривчлах ял хасагдсан. Энэ хүрээнд ШШГЕГ-ын хорих 431 дүгээр ангид ял эдэлж байсан 52 ялтанг баривчлах ялаас чөлөөллөө. 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэгт баривчлах болон ял шийтгэсэн этгээдүүдийг ялаас чөлөөлж байна” гэв. Мөн суллагдсан хүмүүжигчдийг орон нутагт хүргэх унаа болон хоол хүнсний зардлыг төрөөс гаргаж байгаа юм байна.



МОНГОЛЫН МЭДЭЭ
19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУНЦЭЦЭГ 99189158**

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ 90873012**

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД 88096454**

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН 96017873**

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ 99998796**

Маркетинг, зар сурталчилгааны алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710**

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ 99042510**
Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн: **Н.ПУНЦАГБОЛД**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ҮЗЭЛ БОДОЛ

ЖИВХ, “ДАМСК” ИМПОРТЛОГЧДООС УСТГАХ ҮЙЛДВЭР НЭХЭХ ЦАГ БОЛЖЭЭ

...Сонсоход эдгээрийг импортлолсон бол устгах үйлдвэрийг хамтад нь авчрах журам байдаг гэх. Тийм болохоор төр нь оройлоод, импортлогчидтойгоо хамтраад, шийдэл олоод, хурдхан устгах үйлдвэр барих цаг болжээ. Эрх баригчид, яам толгойлогчид нэгийг бодож, хоёрыг тунгаана байгаа...



Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Мөн эмэгтэйчүүдийн ариун цэврийн хэрэглэлийг ч оруулж ирж байгаа олон компани бий. Тэгвэл нэг бяцхан тооцоо хийгээд үзье. Нэг хүүхэд хоёр нас хүртлээ 2000-8000 живх хэрэглэдэг гэсэн Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаа байдаг аж. Жилдээ дунджаар 60-70 мянган хүүхэд төрдөг гэвэл байгальд 350 сая живх байгальд хаягдаж байна гэсэн үг. Дунджаар тооцвол шүү дээ. Ингээд л устгахгүй олон сая живхэндээ даруулах нь. Тийм болохоор нэн яаралтай энэ асуудлыг шийдмээр байна. Зарим хүмүүс живх, эмэгтэйчүүдийн ариун цэврийн хэрэглэлийн импортын татварыг нэмэх хэрэгтэй гэсэн санаа гаргасан байна билээ. Тэглээ гээд живх хэрэглэхгүй байна ч гэж юу байхав. Харин ч үнэ нь нэмэгдэхээс цаашгүй. Тэгээд ч өнөө үед живх, ариун цэврийн хэрэглэл хэрэглэхгүй байна

гэж байхгүй. Хүн бүрийн өдөр тутмын хэрэглээ болчихсон. Хүүхэддээ живх битгий хэрэглүүл, байгальд хортой гэж уриалаад, үглээд ямар ч нэмэргүй. Дэлхий нийтээрээ л хэрэглэж байна. Тийм болохоор живх, ариун цэврийн хэрэглэлийг устгадаг үйлдвэртэй болох цаг болсон. Тэртээ тэргүй живх, ариун цэврийн хэрэглэл устгагчид хамтраад ажиллаж байгаа шүү дээ. Шатаагаад шатахгүй, дээрээс нь хамгийн аюултай хог хаягдал болчихоод байна. Ерөөсөө л бүх хогноос хамгийн сүүлд ялгарч үлддэг байгаа нь живх, ариун цэврийн хэрэглэл. Тиймээс нэн яаралтай живх, ариун цэврийн хэрэглэл, бусад шатагдгүй хогийг устгах үйлдвэр хэрэгтэй байгаа юм. Улс нь ийм үйлдвэр барьж дийлэхгүй байгаа бол импортлогчидтойгоо хамтраад ажиллаж байгаад болохгүй гэж. Ер нь бол хүүхдийн живх, эмэгтэйчүүдийн ариун цэврийн хэрэглэл импортлолж байгаа компани, аж ахуйн нэгжүүдэд шаардлага тавьж, устгах үйлдвэр баруулахад яах

вэ дээ. Та нар нийлээд устгах үйлдвэрээ барь, бид татварын бодлогоор дэмжээд өгье гэж тохиролцоод ажиллаж байгаад болохгүй гэж. Төр засаг гэж байдаг юм бол. Байгаль орчны яам энэ асуудалд анхаарал хандуулж, яаралтай арга хэмжээ авах цаг болсон бус уу. Байгаль орчноо, гол усаа, ой модоо живх, ариун цэврийн хэрэглэлд даруулах аюулаас аврах хэрэгтэй байна. Ердөө нэг том үйлдвэр байхад л болно шүү дээ. Тэр нь хэчнээн үнэтэй байсан ч гэсэн олон импортлогчид хамтраад барьвал хямд тусгах байлгүй. Хэрвээ импортлогчид дангаараа барьж чадахгүй, хөрөнгө мөнгө нь хүрэлцэхгүй гэвэл төртэй хамтарч ч болно. Төр засаг яагаад үйлдвэр барих мөнгөний 40 юм уу 50 хувийг гаргаад, үлдсэн хөрөнгө оруулалтыг нь импортлогчдоос гаргаад, хамтраад ажилласан ч болно. Уг нь бол импортлогчид хамгийн их ашигтай ажиллаж байгаа. Ямар хүүхэддээ живх хийдэггүй ээж. Эсвэл ариун цэврийн

хэрэглэл хэрэглэдэггүй эмэгтэй гэж байх биш. Huggies, Helen Harper, Many Poko, Libero, Pampers гээд долоон жорын живх байна. Дээрээс эмэгтэйчүүдийн хэрэглэлийн олон төрөлтэйг яана. Өдөр, шөнийнхөөс авахуулаад цагийн хэрэглэл л гэж арай алга шиг байна. Ийм их живх, ариун цэврийн хэрэглэл импортлолж, түүнийг нь монголчууд хэрэглэхийн дээдээр хэрэглэж байхад хэдэн тэрбумаар нь ашиг болж байгаа нь тодорхой. Тийм болохоор устгах үйлдвэр барьчих чадал байгаа. Гэхдээ тэд барьтлаа өдий байна. Тэгж байтал Монгол Улс живх, ариун цэврийн хэрэглэлдээ булуулах нь. Сонсоход эдгээрийг импортлолсон бол устгах үйлдвэрийг хамтад нь авчрах журам байдаг гэх. Тийм болохоор төр нь оройлоод, импортлогчидтойгоо хамтраад, шийдэл олоод, хурдхан устгах үйлдвэр барих цаг болжээ. Эрх баригчид, яам толгойлогчид нэгийг бодож, хоёрыг тунгаана байгаа.

Дугаарын **60** мөр

МУБИС үнэд орох цагаар...

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

“Хүүхэд бүрийг хөгжүүлэх чадамжтай бүтээлч багш бэлтгэнэ” уриатайгаар сургалтын хөтөлбөрөө боловсруулж, хүмүүжлийн ажлаа зохион байгуулдаг тус сургуулийн удирдлага, хамт олны санаачлан хийж буй ажил олон. Үүн дээр нэмээд залуусын хамгийн түрүүнд тавьдаг асуултуудын нэг болох “Тэтгэлэгтэй болов уу” гэдэг асуултад “Тийм” гэж харуулав. Тэгэхдээ бүр “ёоз ёозоороо” гэдэг шиг янз бүрийн тэтгэлэгт хөтөлбөрийг зарлаж, оюутнуудынхаа магнайг тэнцүүлжээ юм байна. Тухайлбал, ирэх намраас буюу 2017-2018 оны хичээлийн жилд Монгол Улсын Засгийн газрын 70, 100 хувийн тэтгэлэгт хөтөлбөр, МУБИС-ийн захирлын нэрэмжит 50 хувийн тэтгэлэгт хөтөлбөр, эрэгтэй оюутны 50 хувийн тэтгэлэгт хөтөлбөр, үүнээс гадна кредитийн олон хөтөлбөрүүд бий юм байна шүү, залуус аа. Мөн “Голомт” болон ХААН банк, Зориг сан, Оюутолгой, “Дэлхийн зон” олон улсын байгууллага, Өмнөговь аймгийн нэрэмжит болон аймгуудын ЗДТГ, ИТХ-ын нэрэмжит тэтгэлгүүд байдаг юм байна. Эндээс л олдвол алдаж болохгүй боломж, багш болоход алхахааргүй мэргэжил гэдэг нь харагдаж байгаа юм. Өнөөдөр олон гэр бүл оюутан хүүхдийнхээ сургалтын төлбөрийг хийхийн тулд цалин, тэтгэврээ зээл хэлбэрээр авч, түүнийхээ хүүнд дарлуулж суугаа нь нууц биш. Харин залуус дүү нар минь жаахан хичээхэд л сургалтын төлбөрөө тэтгэлгээр шийдэн өрхийн төсөвтөө учруулж буй дарамтаас чөлөөлөгдөж аав ээжийнхээ сэтгэлийг тэнийлгэж яагаад болохгүй гэж. Нарт хорвоод байхгүй нандин сайхан албанд очих хүнээрээ танай гэр бүл лав бахархана. Гэхдээ “эзэн хичээвэл заяа хичээнэ” гэдгийг мартаж болохгүй. Багш болохын тулд бас тодорхой шалгуурууд бий шүү. Хамгийн эхний нь чин сэтгэлээсээ хүүхдэд хайртай, энэ мэргэжилд үнэн голоосоо дуртай байх хэрэгтэй. Тэгээд элсэлтийн шалгалтын оноо чухал. 2017-2018 оны хичээлийн жилд МУБИС-д математик, байгалийн ухаан, урлагийн багш болохоор элсч буй оюутнууд доод тал нь 600 оноо авах учиртай юм байна. Харин бага ангийн багш болон сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрөө суралцах оюутнууд 550-аас дээш оноотой байх ёстой. Хэрэв та элсэлтийн шалгалтандаа 751-ээс дээш оноо авч чадвал дөрвөн жилийн турш сургалтын төлбөрийн 100 хувийн тэтгэлэгт хамрагдах болзлыг хангана. Харин 650-750 оноотой бол 70 хувийн тэтгэлэгт хөтөлбөрт дөрвөн жилийн турш хамрагдах эрхтэй. Үүнээс гадна багшлах дадлагаа 300-500 мянган төгрөгийн цалинт тэтгэлэгтэй хийнэ гээд бод доо. Харин өдгөө хамгийн дээд оноотой хүүхдүүд тус сургуулийг сонгож байгаа нь сургуулийн олон сайхан болзлыг харсных ч байх, ажлын байр олонтайг ч харгалзсан хэрэг байх. Юутай ч Д.Мөнхжаргал ректор багшийн нэр хүндийг эсвэл тэгснээр ирээдүйгээ эсвэл гэхтэй их үйлдэх чухал хувь нэмэр оруулж яваа аж. МУБИС үнэд орох цагаар...

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Хүчиндүүлсэн хүн нь нэр төрд халдсан болж,

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Улмаар хэргийг хэрэгсэхгүй болгосон учраас би хэвлэлийнхэнд хандаж байгаа нь энэ. УИХ-ын гишүүн Гантулга хүчингийн гэмт хэрэг үйлдсэн, бидэнд нотлох баримтууд нь байгаа. Харамсалтай нь УИХ-ын гишүүн Гантулга цагдаа, шүүхийнхэнтэй хуйвалдаж, маш ноцгой хэргийг нэмж хийсэн. Хүчингийн хэрэг хийгээд зогсохгүй нотлох баримт устгах, хавтаст хэрэг хуурамчаар үйлдэх гэмт хэргийг бүлэглэн үйлддэг байна. Гадаадад улстөрчид биеэ үнэлэгч худалдаж авсныхаа төлөө албан тушаалаасаа огцордог. Гэтэл хүчингийн гэмт хэрэг үйлдчихээд огцрох нь битгий хэл олон хүмүүсийг хөлдөө чирж, гэмт бүлэглэлийг байгуулаад явж байгаан нь хүлээн зөвшөөрмөөргүй байна. Хохирогчийн ар гэрийнхэн хүний эрхийн байгууллагууд болоод надад хандсан. Түүнээс хойш багагүй хугацаа өнгөрч байгаа. Гэхдээ би энэ асуудалд нэлээд болгоомжтой хандаж, хүлээж байсан. Гэтэл байдал эвгүй тал руугаа эргэлээ. Би хохирогч охинтой өөрөө биечилж уулзаад, үнэхээр ойлгосон. Үүний хажуугаар дуугүй өнгөрч болохгүй юм байна. Тэр охин сэтгэл санааны маш их дарамт, цочролд орсон. Цочролоосоо гарахгүй байгаа. Олон охид, эмэгтэйчүүд ингэж бузарлагддаг. Хүүхэд, залуу насандаа хүчирхийлэлд өртсөн охидууд насан туршдаа эдгэшгүй шарх авдаг. Тийм учраас үнэний талд зогсоё, тэр эмэгтэйд тусалъя гэж бид нэгдсэн. УИХ-ын бүрэн эрхийг түдгэлзүүлэх хуулийн заалт байдаг. Гэмт хэрэг үйлдэж байгаад газар дээрээ, нотлох баримттайгаар баригдсан тохиолдолд гишүүний бүрэн эрхийг арилгаж, шалгадаг.



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

Одоо бол тэр гишүүн бүрэх эрх дархтайгаа байгаа. Гэхдээ ёс зүй гаргаж, уучлал гуйгаасай гэж хүсч байна” хэмээн яриллаа.

“Гантулга дүүг минь 10 минут хүчирхийлсэн гэсэн”

Хүний эрхийн хуульч М.Ичинноров мэдээлэл өгсний дараа хохирогч С-ын эгч болсон үйл явдлыг ярьсан юм. Тэрбээр “Би зургадугаар сарын 12-ны шөнө хүүхдээ хараад “Турван гал” эмнэлэгт хоносон. Тэр шөнө болсон хэрэг. Миний найз, ИНЕГ-т ажилладаг Ц гэдэг эмэгтэй амьдрах газар байхгүй гээд нэг хэсэгтээ амьдарч байсан юм. Гэтэл эмнэлэгт хоносоны маргааш өглөө 10:00 цагт утас дуугараад, дүү маань над руу залгасан. “Урьд шөнө Ц эгчтэй хэн ирж хоносон юм бэ. Намайг хүчиндчихээд гараад явчихлаа”

гээд уйлаад ярьсан. Би мэдэхгүй байна, эргээд залгаа гэж хэлчихээд найз руугаа утсаар ярьсан. Тэгээд “Чамтай хамт хэн манайд очиж хоносон юм бэ” гэж асуухад Гантулга гэж харуулсан. Ямар Гантулга вэ гэхэд “Гишүүн Гантулга” гэж хэлсэн. Тэр хүн чинь ийм хэрэг хийчихээд явчихсан байна аа гэтэл “Би мэдээд, сануулаад байсан юм. Чи эртхэн босоод яв аа. Хүүхэд айлгачихав аа гэж хэлсэн. Би шуурхайтай байсан учраас өглөө эрт 06:30 цагаас гараад явсан. Унтаад үлдсэн” гэж хэлсэн. Тэгээд эргэж дүү рүүгээ залгаад, ийм зүйл болсон байна аа гэж хэлсэн. Мөн би Гантулга руу залгасан. Гантулга надтай “Турван гал” эмнэлгийн гадаа ирж уулзсан. Уулзаад “Тийм хэрэг ерөөсөө болоогүй” гэж хэлсэн. Хэрвээ тийм юм бол хууль шүүхийнх нь газар шийдчих байлгүй дээ гээд салсан. Дүү Баянзүрх дүүргийн нэгдүгээр хэлтэс

дээр очиж, Түвшинжаргал гэдэг хүнд өргөдөл өгсөн. Түвшинжаргал гэдэг хүн гэрт ирж нэгжлэг хийсэн. Нөхцөл байдалтай танилцаад, ор хөнгөлийн цагаан хэрэглэл, өөрийнх нь өмсөөд явж байсан дотуур өмдийг авсан. Маргааш нь хэрэг хаагдсан гэсэн. Юунаас болсон гэхэд байцаагч нь солигдчихсон байсан. Түвшинжаргал гэдэг хүн хариуцаж байгаад Батдэлгэр байцаагч шилжж очоод хэргийг яагаад хэрэгсэхгүй болгосныг би өнөөдөр мэдлээ. Прокурордээр очоод “Баянзүрх дүүргийн нэгдүгээр хэлтсийн баримт материалыг үндэслээд энэ хэргийг хэрэгсэхгүй болгов” гэсэн бичиг авсан. Дүү маань сэтгэл санааны хүнд дарамтад орсон. Бид хоёр Сэтгэцийн эрүүл мэндийн төвд очиж үзүүлсэн. Тэгэхэд сул өрөө байхгүй байна, хурцан тасагт хэвтүүлчих үү гэсэн. Сэтгэл санааны хувьд хэцүү

байхад нь хурцан тасагт шууд хэвтүүлчихвэл яах билээ. Тэнд байгаа хүмүүсийг хараад юу бодох вэ, тийм биз дээ. Одоо би нэг зүйлээс айж байна. Энэ бүхнийг ярихаар эргээд хүний нэр төрд халдсан гэдэг хэрэг үүсэх байгаа юм. Яагаад гэвэл Гантулга гишүүн гүтгэж байгаа хүмүүсийг баримттай дэлгэнэ гэж ярьж байна билээ. Хүчин хийсэн гэдгийг үнэхээр гүтгэлэг үү, тийм хэрэг болсон уу гэдгийг нь цагдаа, шүүх нь тогтоож чаддаггүй юм байна. Нууц, хаацайлж, дарлаа. Хүчиндүүлчихээд, нэг хохирчихоод, дахиад хохирогч болох болчихоод байна. Хэнд хандахаа би мэдэхгүй байсан. Ядаж байхад Ерөнхийлөгчийн сонгуулийн цаг хугацаа таарчихсан. Тэгээд хүний эрхийн хуульч Ичинноровт хандсан. Өөр ямар ч арга бидэнд алга. Сая хэвлэлийн бага хурал хийе гээд ирэхэд хүртэл дарамттай байна. Хурал хийх газар нь оруулахгүй гээд бүх сэтгүүлчдийг тараах гээд байж байх жишээтэй. Миний дүү УИХ-ын гишүүн Гантулгыг огт танихгүй, өмнө нь уулзаж байгаагүй. Харин хэрэг болсноос хойш манай найз Ц бид хоёрын дунд үл ойлголцох асуудал цөөнгүй гарсан. Би найзыгаа хүрч ирээд үнэнийг хэлэх байх гэж бодож байна. Өнөөдрийг хүртэл надаас зугтаагаад явж байгаа. Хамгийн гол гэрчийн хувьд үнэнийг хэлэх байх гэж найдаж байна. Миний найз Ц гишүүн Гантулгатай ойр дотны харьцаатай. Гэхдээ хэзээнээс эхэлснийг нь би мэдэхгүй. Гантулга миний дүүгийн хоёр гарыг нь гэжөөд, 10-аад минут хүчирхийлсэн гэсэн. Дүү маань “Алим арилгаж байсан хутга буйдангийн дор байсан. Тэр хутга санаанд орж байсан ч зориг хүрээгүй” гэж хэлж байгаа” хэмээн ярьсан юм.

УЛС ТӨР

САЙД ЯРЬЖ БАЙНА

Д.Оюунхорол: Монголыг дэлхийд таниулах аялал жуулчлалын цогцолборын ажлыг эхлүүлээ

Үргэлжлэл.
Түрүүч нь 1 нүүрт

Тиймээс ч УИХ-ын дарга өөрийнх нь санаачилсан ажил хэрхэн хөрсөн дээр буухыг сонирхож, үзэсгэлэнгийн нээлтэд оролцож, уран бүтээлчдэд баяр хүргэж, амжилт хүссэн. Уралдаанд оролцсон шилдэг 12 багийн бүтээлээр гаргасан үзэсгэлэн Blue mon art gallery-д маргаашийг хүртэл үргэлжлэх учир иргэдийг очиж үзэсгэлэж хүчсэ байна. Энэ төсөл Монголын аялал жуулчлалыг дэлхий дахинаа сурталчлах түүхэн үйл явцны эхлэл юм.

Дэлхий дахины анхаарлын төвд орох томоохон төслийн эхлэлийг амжилттай хэрэгжүүлж, цогцолборынхоо үлгэрийг гаргаад авчихсан гэж ойлгож байна. Ямар компаниудын төлөөлөл оролцсон талаар танилцуулахгүй юу?

–Нийт 12 компани бүтээлээ ирүүлсэн байр шалгаруулж, урамшуулсан. Уралдааны I байрыг “ШУГИС зураг төсөл судалгааны төв” баг, II байрыг “Хаус дизайн” ХХК, III байр “Монгол архитектур дизайн” тусгай байрыг “Эдшил” ХХК-ийн “Дэлүүн болдог дэлхийд болон “Тэнгэрийн тамга” баг тус тус эзэлсэн. Шүүгчдийн бүрэлдэхүүн “Бүх оролцогч ялагч юм шүү” гэдгийг маш сайн захиж байсан учир нийт оролцсон 12 багийн гишүүдээс бүрдсэн ажлын хэсгийг гаргаж, энэхүү төслийг цааш нь үргэлжлүүлэх саналыг шүүгчид гаргасныг сайшаан дэмжиж байгаа. Монголын архитекторуудын чадварыг шалгасан энэхүү үзэсгэлэнд бүтээлээ ирүүлсэн бүх багийнхандаа хандаж, та бүхний гаргасан санал, санаачилга бүрийг Монголыг дэлхийд таниулах энэ том цогцолборт шингээж ажиллахын тулд холбогдох газруудтай нь үргэлж хамтарч ажиллана гэдгээ хэлэхэд таатай байна. Уран бүтээлчид бол цаг хугацаанд элэгдэхгүй мөнхийн бүтээлийг үлдээж чаддагаараа хүндтүүшгүй, бахархууштай хүмүүс шүү дээ.

Манай улсын аялал жуулчлалын салбарын хөгжил ямар шатанд явж байна гэж та хэлэх вэ?

–Ер нь аялал жуулчлал бол тогтвортой хөгжлийн стратегийн гол салбар болоод байна. Дэлхийд жил бүр 1.2 тэрбум жуулчин аялдаг, дэлхийн аялал жуулчлалын салбарын жилийн өсөлт сүүлийн долоон жил дараалан бусад салбарын дундаж өсөлтөөс байнга дээгүүр гарч байгаа. Дэлхийн зургаан хүн тутмын нэг нь жил бүр гадаадад аялал хийдэг, 2030 онд аялагчдын тоо 1.8 тэрбум болох тооцоотой байгаа. Аялал жуулчлал бол ногоон хөгжлийн тэргүүлэх салбарын нэг мөн. Энэ ч утгаараа аялал жуулчлалын асуудал нэг орных биш болж даяарчлал, бүсчлэгдэж байна. Иймээс бид, хоёр хөршгүйгөө нягт хамтран ажиллах шаардлага гарч байгаа. Тухайлбал, гурван улсаар дамжин аялал жуулчлалд нэг орноос нөгөөд ороход хялбар хил гааль, тээврийн үйлчилгээг жигд сайн үзүүлэх нөгөө талдаа улс бүр өөрийн онцлог ялгааг харуулсан аялал жуулчлалын брэнд бүтээгдэхүүнтэй байх хэрэгтэй байна. Энэ утгаараа гурван улсын аялал жуулчлалын удирдлагуудын гэрээ хэлэлцээр хамтын ажиллагааны тохиролцоо нилээд эрчимтэй явж тодорхой үр дүнд хүрээд байгаа. Монголын онцлог аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүдийг гурван чиглэлд гаргах бодлого баримталж байгаа нь байгалийн, түүх соёлын болон эрүүл амьдрал алжаал тайлах гэсэн чиглэл юм. Дэлхийн хөгжингүй орнуудын аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүд ч дээрх багцуудыг аялал жуулчлалынхаа хөгжлийн чиглэлд багтаасан байдаг. Дээр дурьдсан “Мянганы суут хүн-их эзэн Чингис хааны аялал жуулчлалын цогцолбор”-ын ажил нь түүх соёлын чиглэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэхээр

хийж буй томоохон ажлын нэг юм.

–НУБ-аас 2017 оныг тогтвортой аялал жуулчлалын жил болгон зарласан гэж байна. Энэ талаар тодруулна уу?

–Саяхан Филиппиний Манилад болсон аялал жуулчлалын олон улсын хуралд тогтвортой аялал жуулчлал гэж юу вэ гэдэг талаар олон улсын төлөөлөгчид хэлэлцсэн. Энэ үеэр аялал жуулчлалын салбар эдийн засгийн үр дүнд хэт анхаарч байгаад шүүмжлэлтэй хандаж энэ салбараас гарах нийгмийн үр дүн, ялангуяа ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх болон соёл уламжлалыг хайрлан хамгаалахад илүү анхаарах, байгаль орчинд сөрөг нөлөө багатай байх талаас нь цогц байдлаар анхаарч ажиллах тухай онцолсон байгаа.

Монгол Улсын аялал жуулчлалын хувьд ч ялгаагүй нийгмийн үр дүнд илүү анхаарах шаардлага байгаа. Жуулчдад зориулсан үйлчилгээнээс бий болох ажлын байрнаас гадна тухайн байгалийн үзэсгэлэн бүрдсэн нутгийн ард иргэд аялал жуулчлалаас олох үр өгөөж нь морь, тэмээ унуулах төдийнхөөр хязгаарлагдмааргүй байгаа юм. Энэ утгаараа дэлхийн аялал жуулчлалын байгууллагын тодорхойлсноор тогтвортой аялал жуулчлал бол эдийн засаг, байгаль орчин, нийгмийн үр ашиг нь жигд тэнцвэртэй, бүгдэд хүртээмжтэй байх учиртай байгаа юм.

–Монгол Улсад тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд гарч байгаа ямар бэрхшээл байна вэ?

–Монгол Улсад аялал жуулчлалын салбар бусад орныг бодвол хожуу хөгжсөн учир энэ салбарын хувьд туршлага багатай орнуудын тоонд орно. Энэ утгаараа бид эрх зүй, бодлогын орчин, бүтэц байгууллагын чадавхи, статистикийн мэдээ мэдээлэл цуглуулах, түүн дээрээ үндэслэлд төлөвлөлт хийх, бодлого төлөвлөгөөг хэрэгжүүлэх хөрөнгө татах чадвар зэрэг бүх зүйл дээр бусдаас суралцах шаардлагатай, бидний хувьд бэрхшээл болж байгаа зүйлүүд их байна. Юуны өмнө бид аялал жуулчлалын тухай хуулиа орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэн сайжруулах хэрэгтэй байна.

Бодлого хэрэгжүүлэх бүтцийн хувьд, бусад орны жишээг харахад аялал жуулчлалын бүтэц нь тусгай хамгаалалттай газрын менежмент, түүх соёлын өвийн асуудлыг хамт авч явдаг жишиг байдаг. Манайх энэ тал дээр анхаарч уялдуулах зүйлс байгаа.

Аялал жуулчлалын үйлчилгээ, дэд бүтэц дээр үндэсний онцлогтой, гэхдээ дотооддоо нутгийн ялгаатай стратегитэй болохуунийг дагаад үйлчилгээний стандартууд гаргаж мөрдүүлэх зэрэг ажлыг хийхгүйгээр энэ салбар дэлхийн жишигт хүрнэ гэж байхгүй.

Эрх зүй, бодлого цэгцтэй бол хөрөнгө оруулалтын ажлуудыг хувийн хэвшил болон олоун улсын хамтын ажиллагааг эрчимжүүлэх замаар хийхэд дөхөмтэй болно. Энэ мэт бэрхшээл гэхээсээ илүү үндэс суурийг нь тавьж, зоригтойгоор эхлүүлэх ажил их байна.

–Танай яамнаас боловсруулж батлуулаад удаагүй байгаа Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар ярьмаар байна. Хог хаягдлын тухай хуулийг шинэчилэн найруулах болсон шаардлага юу байсан юм вэ?

–Хог хаягдал дэлхий нийтийн тулгамдсан асуудал болоод байна. Техник технологи улам хурдацтай хөгжихийн хэрээр байгальд байдаггүй материалаар хийсэн, байгалийн үйл явцаар бүрэлхэн боломжгүй бараа бүтээгдэхүүнүүд хэрэглээнд маш ихээр орж ирж байна. Эдгээрийг хэрэглээнээс гармагц хэрхэн зөв устгалд оруулах, дахин ашиглах асуудлыг шийдвэрийгээс амьтан, ургамал, хөрсний микро организмуудад ихээхэн сөрөг нөлөө үзүүлж олноороо хордсон

тухай дэлхийн хэвлэл мэдээллээр байнга ярьж байгаа.

Манай улсад ч ялгаагүй автомашин, цахилгаан хэрэгслийн, химийн гээд олон төрлийн хог хаягдлын хэмжээ жил ирэх тутам нэмэгдэж байна. Эдгээрийг хууль, бодлогоор зохицуулж, хэрэглэгчдийг зөв зохистой хэрэглээнд уриалахаас эхлээд амьдралд нь нэвтрүүлэхгүй бол байгаль орчин болон хүний эрүүл мэндэд маш хортой сөрөг нөлөө үзүүлдгийг харуулсан сургаж ч бидэнд байгаа. Иймд үйлдвэрлэл, технологийн дэвшлийг дагаад холбогдох эрх зүй, бодлого хурдан шинэчлэгдэж амьдралд гарч буй асуудлыг шийдэж байх ёстой зарчмын дагуу бид Хог хаягдлын тухай хуулийг шинэчилэн батлуулан.

–Та нэг ярилцлагадаа иргэн хог хаяж байгаа тухай мэдээлэл өгөөд тэр нь баталгаажсан тохиолдолд тухайн хог хаясан этгээдийн торгуулийн мөнгөн дүнгийн 15 хувиар мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулна гэсэн байсан. Энэ мэтчилэнгээр уг хуулийг олон шинэ заалттай байх нь гэж ойлгож байгаа?

–Хуулийн шинэчилсэн найруулга олон онцлог давуу талтайгаас чухал хэдийг дурьдъя. Нэгд, хог хаягдлын менежмент хэрэглээг стандарт нэр томьёо, ойлголтуудыг тодорхой болгосон. Хоёрт, хог хаягдлыг зохицуулахад чухал үүрэг бүхий гол салбарууд болох уул уурхай, эрчим хүч, зам тээвэр, барилга, төсөв санхүү, боловсролын салбарын хариуцлага, үйл ажиллагааны хүрээг зааж өгсөн. Гуравдугаарт, аюултай хог хаягдлын зохицуулалтыг олон улсын шаардлагад нийцсэн байдлаар тусгасан. Дөрөвдүгээрт, аливаа зөрчилд хүлээлгэх хариуцлагыг чангаруулсан. Эцэст нь, иргэдийн хог хаягдлын талаарх боловсрол, мэдээллийн асуудлыг системтэй цогц байдлаар шийдэх заалтууд орсон.

–Хог хаягдлын асуудлыг шийдэхэд эрх зүйн зохицуулалт бий болгохоос гадна тэдгээрийн хэрэгжилтээс үр дүн ихээхэн хамаардаг. Энэ тал дээр танай яам хэрхэн ажиллах төлөвлөгөөтэй байна вэ?

–Хуулийг хэрэгжүүлэх батлуулахаас илүү яригттай. Нэн тэргүүнд манай яамнаас хуулийг сурталчлах ажлыг хийж хурдан хэрэгжүүлэх үүрэгтэй бүх шатны төрийн байгууллагуудын удирдлага, ажилтнууд, нөгөө талаас иргэд, ААН-үүд хуулийг сайн мэддэг байх нь хэрэгжилтийн үр дүнд маш чухал. Үүний зэрэгцээ хэрэгжүүлэх журмыг боловсруулах, аюултай болон хориглосон хог хаягдлыг гаргаж батлуулахаар ажиллаж байна. Мөн 2014 онд баталсан “Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг шинэ хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулах шаардлага байгаа. Энэ хөтөлбөрт хуулийг хэрэгжүүлэх чадавхийг сайжруулах, санхүүжилт, хөрөнгө оруулалтын асуудлууд тодорхой оруулснаар хэрэгжилтийн ажил жигдрэх юм.

–Хууль сурталчлах ажлын хүрээнд танай яамнаас “Цэвэр сайхан орчин” аян зохион байгуулсан байх аа?

–Тийм, өнгөрсөн сарын 2-ноос эхлэн зохион байгуулсан уг аян амжилттай хэрэгжиж байгаа талаар аймаг, дүүргээс мэдээлэл ирүүлж байгаа. Энэ хүрээнд аймаг, дүүргүүд үндэсний их баяр наадмаа хотгүй утгах зорилгоор бүх нийтийн цэвэрлэгээ хийж, холбогдох мэргэжилтнүүд нь иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд болон төрийн байгууллагуудад хуулийн талаарх мэдээллийг түгээх зорилгоор сургалтууд зохион байгуулан ажиллаж байна. Аяныг энэ сарын 7-нд дүгнэх байсан ч Ерөнхийлөгчийн сонгуулийн дахин санал хураалттай давхцсан учир ажлын хэсгийнхэн хугацааны хувьд наашлуулах эсвэл хойшлуулах тал дээр анхааран ажиллаж байна. Мөн энэ



Гэрээ зурвийг Т.АРИУУЖИН

аяны хүрээнд хэвлэл мэдээллийн байгууллага болон студийн дунд Хог хаягдлын тухай хуулийг хэн сайн сурталчлаах вэ нэртэй 5 сая төгрөгийн шагнал бүхий шторкны уралдаан зарласан. Мэргэжлийн байгууллагууд идэвхитэй оролцож байна.

–Танай яамнаас энэ онд боловсруулж батлуулсан бас нэг бодлогын баримт бичиг бол Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр. Энэ баримт бичгийн ач холбогдол юу вэ?

–Энэ хөтөлбөр маань Байгаль орчин, аялал жуулчлалын яам байгуулагдсаны 30 жилийн ойн хүрээнд хийж буйм бас нэг томоохон ажил яах аргагүй мөнөөс гадна сая ярсан Хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлэх нэг механизм юм.

Өмнө нь бохирдлын асуудлуудыг салангид маягаар өөр бодлого төлөвлөлтөд тусгасан байдлаар, санхүүжүүлэгч төсөл хөтөлбөрийн хүрээнд хэсэгчилэн шийдэж ирсэн.

Энэхүү үндэсний хөтөлбөр гарснаар бид бүх төрлийн орчны бохирдлын асуудалд цогцоор нь хандсан, хөгжил бүтээн байгуулалтын төлөвлөлттэй уялдуулсан урт хугацааны нухацтай стратеги зорилго бүхий бодлоготой болж байгаа. Энэ нь дэлхий дахины хөгжлийн төлөвлөлтийн чиг хандлага болох асуудлыг системээр нь авч үзэн бодлого гаргах арга барилаар явж байгаа гэсэн үг.

Бодлого боловсруулсан арга хэлбэрээс гадна бохирдлын асуудал нь өөрөө нухацтай арга хэмжээ авахгүй бол болохгүй хэмжээнд хүрч байна. Энэ талаар хөтөлбөрийн үндэслэлд нарийн тоо баримтууд орсон байгаа.

Хөтөлбөрийн өөр нэг чухал зүйл бол нилээд зоригтой гэж хэлж болох үйл ажиллагаануудыг төлөвлөсөн. Тухайлбал, түүхийн нүүрсний хэрэглээ болон хуучирсан тээврийн хэрэгслийг үе шаттай хориглох арга хэмжээг авахаар тусгасан нь нэлээд эсэргүүцэлтэй тулгараад байгаа.

–Тус хөтөлбөрт тусгасан бусад онцлог үйл ажиллагаануудын талаар ярина уу?

–Бохирдлын асуудлыг дэвшилтэт техник, технологи ашиглахгүйгээр шийдвэрлэх боломжгүй. Иймд хэрэглэгчдэд мэдээлэл, зөвлөгөө өгөх “Байгаль орчинд ээлтэй техник, технологийн мэдээллийн төв”-ийг БЗД, СХД, Чингэлтэй дүүрэгт байгуулахаар болсон. Хэрэгжилтийг санхүүжүүлэх эх үүсвэрийг шийдэхэд Ногоон эзэлийн сан, Агаарын бохирдлыг эсрэг сан зэрэг механизмыг ашиглаж ажиллана. Томоохон ажлууд гэвэл Төв цэвэрлэх байгууламж шинэчлэх, нүүрснээс нийлэг хий үйлдвэрлэх үйлдвэр,

хамтран амжилттай зохион байгуулж байгаа. Засгийн газрын нөөц сангаас энэ жил 450 сая төгрөгийг зохиомлоор бороо оруулах пуужинг худалдаж авахад зориулж гаргаж өгсөн. Одоогийн байдлаар 700 гаруй пуужин ашиглаж, түймэртэй газар болон газар тариалангийн бүс нутгуудад зохиомлоор бороо оруулсан тухай мэдээлэл ирүүлсэн.

Манай яамны зүгээс Богд уул болон Хэнтийн Асралт хайрхан ууланд гал түймэр гарч байх үед нөөц боловцоогоо ашиглан 20 сая төгрөг гарган Богдхан уулын дархан цаазат газрын захиргаа болон Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын захиргаанд хуваарилсан байгаа.

–Хариуцлагагүй уул уурхайн асуудлаас болж байгаль орчин сүйдэж байгааг таниулах ярьдаг ч ямар ч арга хэмжээ авдаггүй. Танай яамнаас энэ асуудал дээр хэрхэн анхаарч, ямар арга хэмжээ авч байна вэ?

–Байгаль орчин хамгаалах хуулийн дагуу олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд шаардлага тавьж, хариуцлага тооцож ажиллаж байгаа. Тухайлбал, Архангай аймагт Орхон голд ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдтэй ажилласан жишээг хэлж болно. Өмнө жил би УИХ-ын зарим гишүүний хамт очиж, үйл ажиллагааг нь зогсоож, Орхон голын эх рүү бохирдол үүсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхээр хэд хэдэн газарт шүүрлийн далан байгуулах ажлуудыг гүйцэтгүүлсэн. Манай яам болон МХЕГ, орон нутгаас хамтран хяналт тавих ажлыг нилээд урт хугацаагаар зохион байгуулсан. Саяхан манай яамны газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг дахин газар дээр нь ажиллаж, мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн шийдвэр гаргуулан хоёр сар хүртэл хугацаагаар дахин үйл ажиллагааг нь зогсоосон. Энэ жилийн үйл ажиллагааг явуулах менежментийн төлөвлөгөөг батлаагүй. Энэ хугацаанд Орхон голын бохирдол эрс багассан талаар нутгийн иргэд манайд мэдээлж байна. Цаашид ч нөхөн сэргээлтгүй хууль журмын дагуу хийхгүй, голын ус бохирдуулах асуудал гарах юм бол тусгай зөвшөөрлийг цуцлуулах дүгнэлт гаргана.

–Ур амьстлын өөрчлөлттэй холбоотойгоор хэт халж, ан амьтан хүртэл харангадаж үхсэн тохиолдол энэ зун нэлээд гарч байна. Тухайлбал, хэт халуунаас болж Дорнодод цагаан эээр үрэгдсэн, хүн нисч чадахгүй байгаа асуудал гарсан. Энэ талаар танай яам ямар арга хэмжээ авч байна вэ?

–Энэ асуудлыг хөндсөнгүй холбогдуулан Дорнод аймгийн “Дорнын их гэгээ”, “Томо буюу цанд” компанийн хамт олойд гүн талархал илэрхийлэхийг хүсч байна. Тус компанийнхан өөрсдийн санаачилгаар нийгмийн хариуцлагаа ухамсарлан харангадаж үхэхийн даваан дээр байгаа амьтдыг аварсан тухай мэдээлэл бидэнд ирүүлэн хамтарч ажиллахаар болоод байгааг дуулгахад таатай байна. Одоогийн байдлаар тус компанийн үйл ажиллагаа явуулдаг талбай орчимд дөрвөн усан цөөрөм байгуулаад байгаа гэсэн. Удахгүй зургаан цөөрөм байгуулах ажлыг эхлүүлэхэд нь манай яамны зүгээс техник арга зүйн зөвлөгөө өгч, холбогдох зөвшөөрлийг гаргаж ажиллахаар болсон. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үндсэн дээр үйл ажиллагаагаа оргожүүлэн тухайн компани цаашид “Зэр хамгаалах сан” байгуулж ажиллахаар болсныг дуулгахад таатай байна. Бид ийм сайхан эсгэлтэй, санаачилгатай, эх оронч хүмүүсийг дэмжиж хамтран ажиллахыг хүсч байна. Манлайлагч хүмүүс олон болбол эх орны маань байгаль үзэсгэлэнтэй хэвээрээ үлдэж хэдэн үеэрээ бахархан үр өгөөжийг нь хүртэн амьдрана шүү дээ.

УЛС ТӨР

ДУУЛИАНЫ ЭРГЭН ТОЙРОНД



Эрдэнэтийн ар дахь НУУЦ ТАЙЛАГДЛАА

Б.ЭРХЭС

26 жилийн түүхэнд анх удаа Ерөнхийлөгчийн сонгууль ялагчгүй болж, Монгол Улс анх удаа дахин санал хураалт хийх асуудал угтаа нийгмийн анхаарлын төвд байх учиртайсан. Тэр тусмаа өнгөрсөн УИХ-ын сонгуулиар үнэмлэхүй олонхи буюу 65 гишүүний суудал авсан МАН-ын нэр дэвшигч яагаад арай ядан жагсаалтын хоёрдугаарт бичигдсэнийг дотооддоо ярилцаж, хариуцлагын асуудал ярих ёстой байлаа. Гэтэл МАН-д энэ асуудал сонин биш бололтой. Үүнийг хэвлэл мэдээлэл бүр өөр өөрийн өнцгөөр тайлбарлаж буй. Тухайлбал, МАН-ын нөлөө бүхий улстөрчдийн нэг С.Баярын тактик хэрэгжиж, тэр санаснаа биелүүллээ гэх дүгнэлтийг сэтгүүлч Б.Дамдин-Очир нийтлэлдээ онцолсон байх юм. “С.Баяр М.Энхболдын засаглалыг 10 жилийн дараа нураалаа” гэх гарчигтай нийтлэлд “С.Баяр Ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон ч М.Энхболдыг нэр дэвшихийг дэмжсэн цаад шалтгаан нь 10 жилийн өмнө Ерөнхий сайдаас буулгасан шиг УИХ-ын даргаас буулгах байж. Тэр рейтинг муу байгааг нь мэдсээр байж нэр дэвшүүлэхийг дэмжсэн нь учиртай” хэмээн бичжээ. Улс төрийн өнцгөөс харвал намын дотоод асуудлыг ингэж дүгнэж болохоор. Нөгөөтэйгүүр, Ерөнхийлөгчийн сонгуулийг тойрсон улстөржилт нэгэн том сэдвийн халхавч болж буйг ч хэвлэл мэдээлэл бичиж, таамаглаж эхэлжээ. Тэр нь “Эрдэнэт” үйлдвэр. Угтаа хөшигний цана суугаа С.Баяр нарт МАН жагсаалтын нэг, хоёрдугаарт бичигдэхээс илүүтэй “Эрдэнэт” үйлдвэрийн хувь хэмжээ л анхаарал хандуулах сэдэв нь болчихоод байгаа гэх. Дахин санал хураалт дөхсөн энэ өдрүүдэд сонгууль гэхээс илүүтэй Эрдэнэт үйлдвэрийг тойрсон хар бараан мэдээлэл улам бүр эрчээ авч байна. Хамгийн сонирхолтой нь энэ мэдээллийг дэвэрэгчид нь МАН-

ын гишүүд өөрсдөө. Энэхүү үйлдвэрийн асуудал нэг жилийн өмнөөс л олны анхааралд өртсөн. Үйлдвэрийн 49 хувийг хувийн хэвшлийн компани худалдан авч, ОХУ-ын “Ростех” компанийн мэдтээс салгаж ирэхэд төрийн мөнгөөр дээрэм хийлээ, энэ бол ард түмний өмч, тиймээс төрийн өмчид авна хэмээн улайрч байсан нь өдгөө ч хэвлэлийн шарласан хуудаснаа тодхон байгаа. Монголын ард түмний өмчийг хууль бусаар дээрэмдлээ хэмээн дээр дооргүй улстөржсөөр УИХ-аар тогтоол батлуулан төрийн мэдэлд 100 хувь авч байсан нь хэдхэн сарын өмнө. Ардын намын нөлөө бүхий улстөрчид ард түмний мэдэлд 100 хувь ирлээ, одоо ард түмэн энэ үйлдвэрээс хувьцаа эзэмших боломжтой, Эрдэнэтийн ард түмний магнай тэнгилээ хэмээн мэдэгдэл хийж байсныг уншигч авхай та санаж буй биз.

Угтаа эх орондоо эргэж ирсэн 49 хувийг төрийн мэдэлд авсан нь ард түмнээ бодсон, эх орончдын хийж буй ажил хэмээж иргэд талархалтай хандаж байсан нь саяхных. Хувийн хэвшлийн дээрэмдсэн үйлдлээ гэд соёлтойгоор иргэдэд ингэж л ойлгуулсан, ард түмэн ч тэгж л хүлээж авсан. Гэвч тийм биш байжээ. Ойрын өдрүүдэд өрнөж буй үйлдвэрийг тойрсон хар мэдээллээс ажихад нэгэнт Монголд ирсэн Эрдэнэтийн тал хувийг нэр бүхий гадаадын компанид дамнуулан зарах асар том хуйвалдаан явжээ гэдэг нь ил болж байна. Энэ хуйвалдааныг ажил хэрэг болгох ажилд МАН-ын нөлөө бүхий улстөрчид оролцон оролцож байгаа талаар ч хэвлэл мэдээллүүд өөр өөрсдийн өнцгөөр таамаг бичиж байх юм. Тухайлбал, МАН-ын тэргүүн стратегич С.Баяр, МАН-ын генсек Д.Амарбаясгалан, УИХ-ын гишүүн Л.Оюун-Эрдэнэ, Шадар сайд У.Хүрэлсүх нарын нэрс дууддаж байх юм. УИХ-ын гишүүн Л.Оюун-Эрдэнэ гэхэд л чуулганы хуралдааны үеэр энэ талаар тун ч тодорхой байр суурийг олонтаа илэрхийлсэн. Төр

бизнесийн хуйвалдаан байж болзошгүй гэх мэтээр улс төрийн ноцтой мэдэгдэл хийж байсан нэгэн. Гэтэл төрийн мэдэлд нэгэнт авчихсан компанийн хувийн хэвшил буцаан дээрэмдэж байгаа мэтээр нийгэмд ойлголт төрүүлэхийг хичээж, олон нийтийн дунд санаатайгаар 100 хувь Монголын мэдэлд ирсэн тус компанийн эсрэг цуурхал тараан, хар бараан мэдээ явуулж эхэлснээс бэлхнээ харагдаж байгаа. Тодруулбал, өчигдрөөс эхлэн иргэний нийгмийн байгууллагууд үйлдвэрийн 49 хувийг хувийн хэвшилд шилжүүлж байгаа нь буруу, шүүх олонгархуудын талд үйлчилж эхэллээ гэх мэтээр асуудлыг дэвэрэгж эхлэв. Чухамдаа улс төрийн тоглоомдоо “Эрдэнэт”-ийг ашиглах, сонгуулийн өдрүүдэд АН-ын нэр дэвшигчид булааж байгаа мэтээр харгалдуулахын тулд эртнээс бэлтгэсэн жүжиг гэдэг нь хэнд ч илхэн болжээ. Мөн өөрсдийн “утсан хүүхэддэй” болсон улстөрчдөө ашиглаж нийгмийн сэтгэлзүйгээр тоглож байгаа нь ажиглагдах болов. Эрдэнэтийн хувийг дамнуулан зарснаар тэдний горьдож байгаа цорын ганц зүйл нь брокерийн хөлс авах. Өөр зүйл бодсонгүй. Эрдэнэтийг ч бодсонгүй, эх орноо ч бодсонгүй, иргэдээ ч бодсонгүй. Ердөө л хялбар мөнгө хийхийг зорьжээ. Харин үүнд Ерөнхийлөгчийн сонгуулийг татан оролцуулж, улс төржилт дээд цэгтээ хүрсэн энэ үеийг ашиглах нь С.Баярын овжин мэх байжээ.

Эрдэнэт анхнаасаа л том улстөрчдийн тоглоомын золиос байсан. Анхнаасаа энэ үйлдвэрийн 49 хувийг төрд булааж авсан үйлдэл нь хууль зөрчсөн байсан ч, ямар ч хамаагүй үнээр гартаа оруулж, төрийн өмчийн компаниас сонгуулийн мөнгө босгоход анхаарсан тухай хэвлэл мэдээлэл хангалттай бичсэн, анхааруулсан. Харин сонгуулийн дараа энэ үйлдвэр хэний гарт очих нь чухал биш. Тэр тусмаа өрсөлдөгчийг харлуулахын тулд Захиргааны хэргийн шийдвэрийг гаргуулж, энэ нь АН-ын улстөрчдийн

захиалга байсан мэтээр нийгэмд ойлгуулах нь МАН-ын стратегийн алсын нүүдэл байжээ. Төрийн өмчийг хувийн хэвшил хэзээ ч хулгайлж авсан түүх үгүй. С.Баяр эртнээс л Эрдэнэт үйлдвэртэй холбогдон яригдаж байсан түүхтэй. Тухайлбал, Эрдэнэт үйлдвэрийн 51 хувь одоо хаана байгаа талаар УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж чуулганы танхимд түүнээс асууж байлаа. Тэрбээр, “Эрдэнэт үйлдвэрийн 51 хувь одоо хаана байгаа нь тодорхой бус. 2009 онд “Жаст”-ын Г.Батхүү гэдэг хүн “Стандарт” банкинд 109 сая ам.долларын барьцаанд тавьсан. Энгийг жирийн бизнесмэн хүн хийхгүй. Далдаас том гар удирдсан. Энэ хүн бол тухайн үед Ерөнхий сайд байсан С.Баяр гэж ойлгодог.

Тэд эртний найзууд. Эрдэнэт үйлдвэрийн 51 хувь Лондонгийн арбитрын биржид байгаа. Гэтэл хувь заяаны тоглоом ч гэх юм уу С.Баяр гэгч Англид элчин сайдаар томилгодоод байна. Тиймээс энэ асуудлаа шийднэ ээ” хэмээн мэдэгдэж байлаа. Гэвч С.Баяр гишүүн хүн гүтгэх нь хуулиар хориглоогүй ч ор үндэслэлгүй мэдээллээр намайг хамаатуулаа гэсэн харилт өгч байв. Энэ мэтээр С.Баяр ба Эрдэнэт эртнээс хамаатаж ирсэн бөгөөд энэ цагт 49 хувь Монголын мэдэлд ирснээр түүний хүсэл битүүхэн биеллээ олж байгаа бололтой. Ерөнхий сайд асан С.Баярын тухайд ганц Эрдэнэт ч бус Оюутолгойн гэрээг хууль бусаар хийсэн хэмээн хэвлэлээр олонтаа алдуулсан. Хууль бус гэрээгээс олсон мөнгөөрөө Англид үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхэлж буй тухай ч УИХ-ын гишүүн асан Г.Уянга хөндөн тавьж байлаа. Тэгэхээр Эрдэнэтийг тойрсон маргаан, үл ойлголцол, хар бараан мэдээлэл, зохион байгуулалттай турхиралт зүгээр ч нэг хийгдээгүй нь эндээс харагдаж буй юм. Төрд авчихсан өмчийг сонгуулиар дуулиан болгож буй хөшигний цаадах учир шалтгаан тайлагдаж буй бололтой.

ДЭЛХИЙ ШИНЗО АБЭГИЙН НАМ ТҮҮХЭН ЯЛАГДАЛ ХҮЛЭЭЛЭЭ



Б.ДАВААХҮҮ

Японы нийслэл Токио хотын парламентын сонгууль Янгөрөгч ням гарагт болж, өчигдөр өглөө үүрээр үр дүн нь тодорхой боллоо. Улмаар тус улсын Ерөнхий сайд Шинзо Абэгийн тэргүүлдэг эрх баригч Либерал Ардчилсан нам түүхэндээ байгаагүй хэмжээний томоохон ялагдал хүлээсэн байна. Токиогийн ассамблей 127 суудалтай. Сонгуулиас өмнө Либерал Ардчилсан нам 57 суудалтай байжээ. Гэвч энэ сонгуулиар ердөө 23 суудлыг авч чадсан бол Юрико Койкэгийн “Tokyo Citizens First” нам үнэмлэхүй олонхи болж, 79 суудал авчээ. Ингэснээр энэ удаагийн сонгуулийн дүн эрх баригч намд томоохон цохилт боллоо. Сонгуулийн үр дүнтэй холбогдуулан Батлан хамгаалахын сайд асан Шингэру Ишиба “Бид түүхэн ялагдлаа хүлээн зөвшөөрөх ёстой” гэж хэлснийг NHK агентлаг иш татжээ. Токиогийн парламентын сонгуулийг Японы доод танхимын урьтал сонгууль ч гэж үздэг аж. Тийм ч учраас улс төрийн томоохон намууд бүхий л хүчээ дайчлан оролцдог байна. Эрх барьж буй нам парламентад талаас илүү суудал авч чадах эсэх, Либерал ардчилсан нам байр сууриа хадгалах эсэх нь хамгийн их анхаарал татсан үйл явдлын нэг байдаг аж. Гэвч энэ удаагийн сонгуульд Либерал Ардчилсан нам байр сууриа “Токиогийн иргэд нэгдүгээрт” намд алдлаа. Өнгөрсөн хугацаанд Шинзо Абэгийн нам 1965 болон 2009 онд түүхэндээ анх удаагаа тус парламентад 38 суудал авч байжээ. Харин энэ удаа түүнээс 10 гаруй суудлаар бага буюу Комэй намтай нийлж 23 суудал авч, хоёрдугаарт бичигдсэн байна.

Токиогийн парламентын сонгуулийг дэлхийн хэвлэлүүд ч янз бүрээр мэдээлж байв. Тухайлбал, “Ройтерс” агентлаг “Түүхэн ялагдал хүлээлээ. Хэд хэдэн дуулиан шуугианы дараа дэмжигчдийнх нь хувь буурсан Шинзо Абэгийн Засгийн газарт

томоохон бэрхшээл тулгарахыг энэ удаагийн сонгууль харуулав” гэсэн бол “Ассошэйтед пресс” “Дэмжигчдийн хувиа тогтвортой хадгалж ирсэн Шинзо Абэгийн нам сонгуульд ялагдахад намын дотоодод үүссэн дуулиан нөлөөллөө. Харин эсрэгээр Койкэгийн нам ялалт байгууллаа” гэжээ. Франц пресс мөн энэ талаарх мэдээллийг дамжуулжээ. Түүнд “Хэдий орон нутгийн сонгууль ч, гэсэн өнөөгийн Засгийн газарыг ард иргэд хэрхэн дүгнэж буйг харуулсан чухал үзүүлэлт боллоо. Токиогийн иргэдийн ихэнх нь хуучин Консерватив хүчнийг сэгсэрч, Койкэгийн намын бодлогыг дэмжлээ” гэсэн байна. Мөн манай урд хөршийн хэвлэлд “Койкэгийн нам дэмжигчдээ алдсан Либерал Ардчилсан намыг ялах эсэх нь анхаарал татаж байна. Сонгуульд Либерал Ардчилсан нам хэрэв ялагдвал, цаашдаа Шинзо Абэгийн Засгийн газарт томоохон нөлөө үзүүлж магадгүй” хэмээн нийтэлсэн байжээ. Энэ мэтээр Токиогийн парламентын сонгууль дэлхийн хэвлэл мэдээллийн анхаарлыг татлаа.

Д.Трампыг огцрохыг шаардан жагслаа

АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трампыг огцруулахыг шаардсан жагсаал АНУ-ын өнцөг булан бүрт өрнөжээ. Пенсильвани, Охио гэх мэт мужийн нийтдээ 45 хотод Д.Трампын кабинет, ОХУ-тай холбоотой гэх мэдээлэл зэргээс үүдэн Ерөнхийлөгчөө огцруулахыг шаардсан жагсаал зохион байгуулагдсан байна. Тэдгээрээс хамгийн томоохон жагсаал нь Лос-Анжелест болсон байна. Тус жагсаалд 5000 гаруй хүн оролцжээ. Жагсагчид “Trump no” гэх

мэт үгс бичсэн лоозон барьж, нэг км орчим зам алхсан байна. Тус жагсаалд оролцогч нэг эмэгтэй “Ерөнхийлөгч Д.Трамп Америк төдийгүй, дэлхий дахиныг сүйрэл рүү хөтөлж байна” хэмээн эсэргүүцлийн хөдөлгөөнд оролцсон шалтгаанаа тайлбарласан байна. Мөн “Ерөнхийлөгчийг огцруул” гэх үгтэй цамц өмссөн өөр нэг эрэгтэй “Ерөнхийлөгч өөрт ногдсон гол ажлаа биш, өөр эрсдэлтэй үйл ажиллагаанд оролцож байна” гэж ярьжээ.



Б.Ассадын хөрөг бүхий мөнгөн дэвсгэрт гарчээ

Сирийн төв банк тус улсын Ерөнхийлөгч Башар Ассадын хөрөг зураг бүхий 2000 сирн фунтын шинэ дэвсгэртийг гүйлгээнд оруулжээ. Төв банкны дарга Дуриад Дургамын хэлснээр, шинэ 2000 фунтын дэвсгэртийг гаргахаар хэдэн жилийн өмнөөс төлөвлөсөн боловч тус улсад дайн дэгдэж, инфляци өсч байгаагаар холбоотойгоор хойшлуулсан аж. “Одоо хуучин мөнгөн дэвсгэртүүд элэгдэж муудаж байгаа тул мөнгөн дэвсгэртийн сангаа шинэчлэх цаг болсон” гэж Д.Дургам ярилаа. Өмнөх 1000-тын дэвсгэрт дээр 1971-2000 онд засгийн эрхийг барьж байсан Башарын эцэг Хафез Ассадын хөрөг зураг байдаг аж. 2000 фунтын дэвсгэрт өмнө нь эргэлтэд байгаагүй аж. 2011 онд Сирид иргэний дайн эхэлснээс хойш Сирийн мөнгөний ханш огцом унасан юм. Дайнаас өмнө нэг ам.доллар 47 сирн фунттай тэнцэж байсан бол одоо 500 гаруй фунттай тэнцэх болжээ.

ОХУ-д 14 хүн амиа алдлаа

ОХУ-д хот хоорондын зорчигч тээврийн автобус, ачааны машинтай мөргөлдсөний улмаас 14 хүн нас баржээ. Тэдний хоёр нь хүүхэд байсан тухай холбогдох албаныхан мэдээлсэн байна. Хэргийг Холбооны мөрдөх товчооноос шалгаж буй бөгөөд автобус Самарагаас Изhevскийг чиглэн явах замдаа нийслэл Москвагаас зүүн тийш 900 км зайд авто осолд өртжээ. Автобусны жолооч хурц гэрлийн улмаас өмнөөс нь ирж явсан ачааны машиныг олж хараагүй хэмээн мэдүүлсэн байна. Эсрэг урсгалаар явж байсан хоёр тээврийн хэрэгсэл мөргөлдсөний дараа автобус



замын хажуу руу унаж, удалгүй шатжээ. Одоогоор албаныхан ачааны машин болон автобусны жолоочийг осолд буруутган баривчлахаар төлөвлөсөн байна. Мөн автобусны компанийг шалгаж байгаа гэх мэдээлэл байгаа ч, хэрэгт холбогдолтой эсэх нь тодорхойгүй байгаа юм.

Туркид 45.4 хэм хүртэл халжээ

Туркид энэ сарын 2-нд 45.4 хэм хүртлээ халжээ. Урьд өмнө нь тус улсын түүхэнд 45 хэм хүртлээ халж байсан тохиолдол байгаагүй аж. Анадоли агентлагийн мэдээлснээр гадаадын жуулчид олноороо зорин очдог нийслэл Анталья хотод 45.4 хэм хүртлээ халсан байна. Мөн тус улсын хамгийн том хот Истанбулд 39.3 хэм хүртлээ халжээ. Хэт халсны улмаас гудамж хүнгүй болж байсан гэнэ. Туркийн баруун этгээдийн

Измир мужийн Мендерес дүүргийг ойд гал түймэр гарч, 500 га талбай өртсөн байна. Гал түймрийг унтраахын тулд есөн нисдэг тэрэг, дөрвөн онгоц дайчлагджээ. Тухайн бүс нутагт нийтдээ нэг долоо хоногийн өмнөөс хэт халалт эхэлсэн бөгөөд өнөөдөр ихэнх бүс нутагт бороо орно гэсэн мэдээлэл байна. Турктай хиллэдэг Грект ч гэсэн хэт халж, Афин зэрэг хотуудад +43 хэм хүрч байгаа аж.

МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛЫН АРД ИРГЭДДЭЭ ХЯТАД МОНГОЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГААР ДАМЖУУЛАН АЗ ЖАРГАЛТАЙ АМЬДРАЛЫГ ХҮСЭН ЕРӨӨӨ!



Долдугаар сар бол Монгол Улсын хамгийн үзэсгэлэнтэй улирал. Монголын ард түмэн тун удахгүй үндэснийхээ их баяр наадмыг тэмдэглэх гэж байна. Энэ завшааныг ашиглан нийт Монголын ард иргэддээ баяр наадмын мөнд дөвшүүлэн аз жаргалтай түвшин сайхан амьдрахыг хүсэн ерөөе.

Ойрын өдрүүдэд, БНХАУ-ын дарга Ши Жиньпин ОХУ болон ХБНГ Улсуудад төрийн айлчлал хийх бөгөөд "Их 20"-ийн арванхоёр дах удаагийн дээд хэмжээний уулзалтад оролцох гэж байна. Айлчлалын үеэр, Ши Жиньпин дарга ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин болон ХБНУ-ын Ерөнхийлөгч Ф.В.Штайнмайер, Ерөнхий сайд Ангела Меркел нартай тус тус уулзаж, олон арга хэмжээнд хамтдаа оролцож, Орос болон Герман улсуудтай цаашид улс төрийн харилцан итгэлцлийг гүнзгийрүүлж, хоёр талын олон салбар дахь бодит хамтын ажиллагааг ахиулж, бүс нутаг болон дэлхийн энх тайван, хөгжил цэцэглэлтэд шинэ хувь нэмрээ оруулахаар зорьж байна.

Ши Жиньпин дарга Германы Гамбургт болох Их 20-ын бүлгийн дээд хэмжээний уулзалтын үеэр дэлхийн эдийн засгийн байдал болон олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны талаарх санал бодлоо танилцуулж, улс орнуудын хоорондын төрийн бодлогын зохицуулалтыг бэхжүүлж, дэлхийн эдийн засгийн хамтдаа хүчирхэг, тогтвортой, тэнцвэртэй хүртээмжтэйгээр өсгөх талаар хэлэлцэнэ. Гамбургийн дээд хэмжээний уулзалт "Хамтдаа урагшлах дэлхийн цогцлоон бүтээх" гэсэн сэдвийн дор явагдана. Уулзалтаар дэлхийн эдийн засгийн байдал, гадаад худалдаа, банк санхүү, тоон эдийн засаг, эрчим хүч, хөгжил дэвшил, терроризмын эсрэг зэрэг сэдвүүдийг хэлэлцэж, хурлын дараагаар олон нийтэд мэдэгдэл гаргах болно. Хятадын талаас энэ удаагийн уулзалтаар Хан Жоу хотод болсон Их 20-ын бүлгийн дээд хэмжээний уулзалтын үр дүнг ажил хэрэг болгох, Нээлттэй дэлхийн эдийн засгийг бий болгох, инновацийн хөгжлийг хамтдаа урагшлуулах, Их 20-ын бүлгийн гишүүн орнууд эв нэгдэлтэй хамтран ажиллах гэсэн мессеж дэлхий нийтэд өгөхийг хүсч байна. Саяхан, Ерөнхий сайд Ли Көчян Даосын 11 дэх удаагийн зуны чуулга уулзалт дээр дэлхийн эдийн засгийн чиг хандлагийн талаар гүн гүнзгий дүн шинжилгээ хийсэн бөгөөд эдийн засгийн глобалчлал болон хүртээмжтэй хөгжлийн чиглэлээр "Хятадын төлөвлөгөө"-г дэвшүүлж, мөн хятадын эдийн засгийн байдал, шинэчлэлийн санаачилгаа танилцуулсан.

Хятад улс үргэлж дэлхийн эдийн засгийн сэргэлт, тогтвортой байдал болон өсөлтийн төлөө хувь нэмрээ оруулсаар ирсэн. Энэ жилийн 5-р сард, "Нэг бүс нэг зам" олон улсын хамтын ажиллагааны дээд хэмжээний чуулга уулзалт Бээжин хотноо зохион байгуулагдлаа. Энэхүү санаачилга нь Хятад Улсын дэвшүүлсэн "Нэг бүс нэг зам"-ын бүтээн байгуулалтын хүрээнд зохион байгуулсан анхдугаар дээд хэмжээний бөгөөд хамгийн өргөн хүрээтэй олон улсын хурал болсон. Энэ удаагийн чуулга уулзалтад дэлхийн 29 улс орнуудын төрийн тэргүүн, Засгийн газрын тэргүүн мөн 130 гаруй улс орны, 70 гаруй олон улсын байгууллагын 1500 төлөөлөгчид оролцсон. БНХАУ-ын дарга Ши Жиньпин чуулга уулзалтыг нээж чухал сэдвээр илтгэл тавьсан юм. Чуулга уулзалтын үеэр өндөр, дээд хэмжээний хурал, дутуй ширээний уулзалт зохион байгуулж, улс орнуудын удирдагч нартай төрийн бодлого, дэд бүтэц, гадаад худалдаа, санхүүжилт болон ард иргэдийн харилцааг уялдуулан холбох асуудлаар өргөн хүрээнд санал бодлоо солилцож, олон чухал тохиролцоонд хүрч, хамтарсан мэдээлэл гаргасан. Энэ бол талууд хамтран зөвшилцож, "Нэг бүс нэг зам"-ыг хамтдаа бүтээж, харилцан ашигтай хамтын ажиллагааны үр өгөөжөө хамтдаа хүртсэн уулзалт мөн бөгөөд олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлж, тус бүрийн хөгжлийн стратегийг харилцан уялдуулан хамтын ажиллагааны чухал тавцан болсон. Энэ удаагийн дээд хэмжээний чуулга уулзалт үр өгөөж арвин байсан. Чуулга уулзалтаар ирээдүйн "Нэг бүс нэг зам"-ын хамтран ажиллах чиглэлийг тодорхойлсон, "Нэг бүс нэг зам"-ын тодорхой маршрут зургийг төлөвлөн гарсан, "Нэг бүс нэг зам" –тай холбоотой удахгүй хэрэгжих томоохон хэмжээний төслүүдийг баталсан арвин их үр бүтээлтэй баяр хөөхөөр дүүрэн болж өнгөрсөн.

Монгол Улс бол "Нэг бүс нэг зам"-ын шугам дагуух чухал улс. Монгол Улсын Ерөнхий сайд эрхэмсэг ноён Ж.Эрдэнэбат тус чуулга уулзалтад урилгаар оролцож, МУ "Нэг бүс нэг зам"-ын бүтээн байгуулалтад ихээхэн идэвх гаргаж оролцох эрмэлзэлтэй байгаа гэдгээ бүрэн илэрхийлсэн. Энэ нь Хятад Монголын харилцаа өндөр түвшинд байгааг харуулсан. Чуулганы уулзалтын үеэр Хятад Улсын дарга Ши Жиньпин, Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Ли Көчян, Дэд ерөнхий сайд Ван Яан зэрэг удирдлага нар тус тус Төрийн эрхэмсэгтэй уулзалт зохион байгуулж, хоёр улсын удирдлага нар Хятад Монголын цаашдын харилцааны хөгжил, хамтын ажиллагааны асуудлаар олон чухал тохиролцоонд хүрсэн. Талууд улс төр, эдийн засаг, хүмүүнлэгийн зэрэг олон салбарын хамтын ажиллагааны 20 гаруй баримт бичигт гарын үсэг зурсан. Мөн Хятадын талаас Монголын талд үзүүлж буй тэрбум ам.долларын хөнгөлөлттэй эзэлийн төслийн Монголын талын санхүүжилтийг ихээр бууруулж, юань төрөгийн своп хэлцлийн хугацааг сунгаж, Хятад Монголын хүмүүнлэгийн солилцооны хамтарсан зөвлөлийг албан ёсоор байгуулахыг шийдвэрлэсэн зэрэг томоохон хэлэлцээрүүд багтаж байна. Ши Жиньпин дарга

Хятадын талаас Монголд буцалтгүй тусламж нэмж үзүүлэхээ мэдэгдсэн. Монголын хэвлэл мэдээлүүд энэ талаар "Ганзага дүүрэн аялал" хэмээн нэрийдсэн байна.

Хятадын тал Хятад Монголын харилцаанд өндөр ач холбогдол өгч байгаа бөгөөд Хятад Монголын харилцааг хөгжүүлэх асуудлыг өөрийн гадаад харилцааны бодлогын нэн тэргүүн чиглэл болгон авч үздэг. 2014 онд Ши Жиньпин дарга Монгол Улсад түүхэн айлчлал хийж, хоёр улсын харилцааг Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа болгож дээшлүүлсэн. Ши Жиньпин дарга удаа дараа олон улс болон бүс нутгийн байдал яаж ч өөрчлөгдсөн Хятадын тал ямагт Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал болон Монголын ард түмэн өөрөө сонгосон хөгжлийн замаа хүндэтгэхээ онцлон тэмдэглэсээр ирсэн бөгөөд энэ нь Хятад Улсын урт хугацааны туршид баримтлаж буй үндсэн бодлого гэдгийг онцлоосор ирсэн. Олон улсын байдал яаж ч өөрчлөгдөж байсан, Хятад Монгол бид бүгд хоёр талын харилцааны ерөнхий чиглэлээ сайтар баримтлан, иж бүрэн стратегийн түншийн харилцааны өнцгөөс бие биенээ бодолцож, бие биенийхээ бүрэн эрх, үндэсний аюулгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал зэрэг гол ашиг сонирхол болон нөгөө талынхаа язгуур ашигтай холбоотой томоохон асуудалд тууштай, харилцан дэмжлэг үзүүлж байх хэрэгтэй. Хятадын тал цаашид ч хөршүүдтэйгээ найрсгаар харилцах, түнш болох зарчмыг барьж, эвсэг хөрш, амгалан хөрш, баян хөрш байх бодлогоо идэвхтэй авч хэрэгжүүлж, Монгол Улстай элэгсэг дотно, үнэнч шударга, үр ашигтай, хүртээмжтэй гэсэн үзлээ хэрэгжүүлж, чин үнэнч сэтгэлээр Монгол Улсын хөгжилд дэмжлэг тусалцаа үзүүлсээр байх болно. Хятад Улс Мээнэл Улс болон бусад хөрш орнууддаа хамтдаа хөгжих боломж болон орон зайг олгоход бэлэн байгаа бөгөөд, Монгол Улсыг Хятад Улсын хөгжлийн хурдан галт тэргэнд суухыг урьж байна. Хурдан галт тэргэнд суусан ч болно, дайгдсан ч болно. Ганцаараа явбал хурдан явна, Олуулаа явбал хол явна гэсэн үг байдаг. Бид бүгдийг нь таатай хүлээж авах болно. Хятад Улс Монголтэй худалдаа эдийн засгийн бодит хамтын ажиллагаагаа өргөжүүлж байгаа ч зөв шударгаар ашигаа хуваахад болно. "Би хожиж, чи хожигдоно", "би ихийг, чи багыг" гэх асуудал байхгүй бөгөөд зайлшгүй харилцан ашигтай, хамтын ажиллагааг биелүүлж, зарим тодорхой төслүүд дээр Монголын талд илүү ашгийг хүртээх болно.

Сүүлийн үед Хятад Монголын бодит хамтын ажиллагааны талаар худал, харилцаагүй үг яриа гарч байгааг анзаарлаа. Үүнд миний бие тайлбар, залруулга хийхийг хүсч байна. Дэлхий нийтээр ажиглахын бол БНХАУ буцалтгүй тусламж олгосон аль ч оронд ямарваа нэг дагалдах нөхцөл тавьдаггүй. Энэ бол бидний зарчим. Бидний Монголын талд олгож байгаа буцалтгүй тусламжийн гол зорилго нь Монголын ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, Монгол Улсын эдийн засгийн "цус сэлбэл" чадамжид дэмжлэг тусалцаа үзүүлж, гар нийлж хамтдаа хөгжих бодлогоо илүү сайнаар хэрэгжүүлэх юм. Энэ утгаараа тусламж бол ямар нэгэн үнэгүй хоол гэх зүйл биш, харин бялуу бөгөөд бидний хамтдаа хуваахад хөгжлийн ашиг юм.

Хятад хүмүүс итгэлцлийг эрхэмлэдэг. Хятад хүмүүс хэлсэн л бол, амласан л бол, заавал хэлсэнээ хэрэгжүүлдэг, амлалтаа биелүүлдэг. Ойрын жилүүдэд, Хятадын тал хоёр улсын удирдагчдын хамтын ажиллагааны тохиролцоонуудыг бодитоор тууштай хэрэгжүүлэхээр Монголын талд хөрөнгө санхүү, техник технологи, төслүүд дээр бүх талаар дэмжин ажиллаж байна. Хятад Монголын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа арвин их үр өгөөжтэй байгааг бүгд харж байгаа.

Хятад Монголын гадаад худалдааны хувьд Монголын Засгийн газраас гаргаж буй статистик үзүүлэлтээр өнгөрсөн 10 жилд (2007-2016онд) Монголын гадаад худалдаа алдагдалтай (Өнгөрсөн 10 жилд нийт 4тэрбум 600сая долларын алдагдалтай) ажиллаж байгаа боловч Монгол Хятадын худалдаа ашигтай байсаар ирсэн. Монгол Хятадын худалдаа ашиг нь энэ 10 жилд 18тэрбум 800сая ам.долларт хүрсэн байна. Өөрөөр хэлбэл өнгөрсөн 10 жилд Монгол хүн болгонд Монгол Хятадын худалдааны ашгаас дунджаар цэрвэр дүн 7000 ам.доллар хүртсэн байгаа нь Монголын хүний дундаж орлогыг өсгөснийг харуулж байна. Үүнээс үзэхэд Хятад Монголын гадаад худалдаанаас Монголын тал бодитой ашиг хүртэж байна.

Монгол дахь хөрөнгө оруулалтын хувьд БНХАУ Монгол Улсад том хэмжээний газрын тосны орд байгуулж, хөрөнгө оруулалтыг хийснээр Монгол Улс газрын тос экспортлох үйлдвэртэй болж Монголын газрын тосны хомсдолтой улс байсан түүхийг өөрчлөн аж үйлдвэрийн суурийг тавьж өгсөн. Хятадын тал Монгол Улстай олон цахилгаан станцын төслийг хэрэгжүүлэх тухай идэвхитэй ярилцаж байгаа бөгөөд цахилгаан станц баригдсанаар Монголын цахилгаан эрчим хүчний хомсдол болон импортын асуудлыг шийдэх боломжтой. Амгалан дулааны станц нь Улаанбаатар хотын хамгийн шинэлэг орчин үеийн, байгаль орчинд аюулгүй дулааны станц бөгөөд дунджаар 100мянган айл өрхийг өвлийн хүйтэнд дулаанаар хангаж, хотын зүүн хэсгийн дулааны хомсдол болон агаарын бохирдлыг шийдэж өгч чадсан. Хятадын аж ахуй нэгж Монгол улсад чанартай, өндөр түвшиний ариула байгууламжуудыг хүлээлгэн өгсөн бөгөөд гүүр, зам, хот тохижуулалт, үйлдвэр, уул уурхай гэх мэт томоохон төслүүд дээр ажиллаж, монгол улсад ойролцоогоор 100мянган ажлын байрыг бий болгож, нийт төлсөн татваруудын хэмжээ 2тэрбум

ам долларт хүрээд байна.

Буцалтгүй тусламжийн хувьд: Хятадын талаас гаргасан буцалтгүй тусламжид ямар ч нэмэлт нөхцөл ороогүй бөгөөд бүхэлдээ Монгол Улсад нэн шаардлагатай байгаа нийгмийн халамжийн үйлст бодитоор зарцуулагдаж байгаа. 2014 оны 8-р сард ,2017 оны 5-р сард Ши Жиньпин дарга Монголын талд юаний буцалтгүй тусламж өгөхөө мэдэгдэв. 2016 оны 7-р сард Ерөнхий сайд Ли Көчян Монголын талын хугацаа дууссан төлөгдөөгүй, хүүгүй бүх эзэлийн өрийг тэглэж чөлөөлсөн. Хятад Улсаас олгосон буцалтгүй тусламжаас Монгол Улсын нэг иргэн дунджаар хэдэн мянган ам.долларын ашиг хүртэж байгаа. Ядуурлаас гаргах хүн ам ихтэй хөгжиж буй орны хувьд энэ нь Хятад Улсын ЗГ, Монгол Улсын ЗГ болоод ард түмэнд үзүүлж буй харамгүй тусалцааг бүрэн харуулж байна.

Дээр дурьдсан санхүүгийн дэмжлэгүүдээр, Хятадын тал Монголд их хэмжээний өнөөгийн нийгэм эдийн засгийн хөгжилд ахиц дэвшил болсон голлох төслүүдийг хэрэгжүүлж, Монголын ард иргэдийн амьжиргааны түвшинг сайжруулахад, дэд бүтцийн түвшинг дээшлүүлэхэд тусалсан. Жишээ нь Монголын хамгийн анхны хурдны автозамыг барих, аймгуудыг холбосон олон олон замын барилга угсралт, засварыг хийж, баруун аймгуудын хооронд засмал зам байдаггүй байсан түүхийг эцэслэсэн. Нийт дүнгээр шинээр барьсан болон засварласан автозам 1000 километр хүрээд байна. Мөн Монгол Улсын хамгийн анхны бүс нутаг дамнасан цахилгаан дамжуулах шугамын төслийг эхлүүлсэн. (УБ-Мандалговь цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төсөл) Энэ нь Монголын өмнөд бүсийн эдийн засгийн хөгжилд хүчтэй баталгаа болж өгч байгаа юм. Мөн Монголын бүх аймгуудыг бүрхсэн мэдээлэл харилцааны тулгуур сүлжээ болон боловсрол, эмнэлэгийн цахим сүлжээг бий болгож компьютержүүлэлтийн түвшинг маш ихээр сайжруулсан. Их хэмжээний ардын амьжиргааны орон сууц, анагаах, боловсролын зэрэг салбарын төслүүдийг хэрэгжүүлж, гэр хорооллын дахин төлөвлөлтийн бүтээн байгуулалтад 5000-н айлын орон сууц, нийт 300 мянган м2 бүхий бүтээн байгуулалт бий болгосон. Туул гол дээгүүрх 2 төмөрбетон гүүр, төмөр зам дээгүүрх 2 гүүрэн гарцын барилгын ажилууд ойрын өдрүүдэд бүтд эхлээд байна. Ашиглалтад орсныхоо дараа Улаанбаатар хотын зам тээврийн хурцадмал байдлыг хөнгөвчлөх ихээхэн ач холбогдолтой. Хятадын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй маш олон төслүүдийн бүтээн байгуулалтад олон тооны Монголын компани, Монгол ажилчид оролцож, энэ нь тухайн орон нутагт цөөнгүй ажлын байр бий болгосон.

Мөн миний бие Монголын бүх түвшинд анхаарлын төвд гол сэдэв болж байгаа Хятад Монголын Уул уурхай, эрчим хүчний хамтын ажиллагааг онцолж дурьдмаар байна. Шулуулан хэлэхэд, Хятад Улсын хувьд одоогийн байдал уул уурхайн эрчим хүчний нээн олборлолт нь нэн тулгамдаж буй асуудал бишээ. Эсэргээрээ, Хятадын эдийн засаг тасралтгүй тогтвортой хурдацтайгаар өсч байгааг хажуугаар, тулгарч буй гол асуудал нь олборлолтын илүүдэл. Ялангуяа, төмөрлөгийн болон нүүрсний салбарт Хятад Улс эрэлтээсээ хэт давсан үйлдвэрлэлийн илүүдлийг бууруулах асуудалтай тулгараад байгаа. 2016 оны байдлаар, улсын хэмжээнд нийтдээ ган төмөрлөгийн үйлдвэрлэл 65сая тонн, нүүрсний уурхайн олборлолт 290сая гаруй тоннор эрэлтээс давж улсын хэмжээнд 1500 орчим 300мянган тонноос доошх жижиг нүүрсний уурхайнуудыг татан буулгасан. 2017 оны Засгийн газрын ажлын төлөвлөгөөнд тавьсан үйлдвэрлэлийн илүүдлийг бууруулах зорилтийн дагуу, энэ жил дахин төмөрлөгийн үйлдвэрлэлийг 50 сая тонноор багасгаж, нүүрсний олборлолтыг 150сая тонноор болиулж байгаа. Ойрын хэдэн жилийн урьдчилсан тооцооллоор, жил бүр нүүрсний олборлолтыг 100сая тонноор бууруулах болно. Энэ бол маш олон ажлын байр болон эдийн засгийн хүндрэлийг дагуулж ирэх хүндхэн үүрэг.

Илэн далангүй хэлэхэд, нүүрсний хамтын ажиллагаа явуулах нь цэвэр Монголд өөрийн нөөц бололцоо, давуу талаа бүрэн дүүрэн ашиглахад нь туслах зорилготой, түүнээс бидний нүүрсний эн тэргүүний хэрэгтэй биш. Хятадын талд дотооддоо нүүр болон ган төмрийн үйлдвэрлэлийн илүүдэлтэй хүндхэн нөхцөлд байгаа хэдий ч Хятад улс Монголын талын хүсэлтийн дагуу уул уурхайн хамтын ажиллагаагаа явуулж байгаа. Хамтын ажиллагааны цар хүрээ, ахиц явц бүхэлдээ Монголын талаас хамааралтай. Хэрвээ бүх талын нөхцөл байдал бэлэн болсон тохиолдолд Хятадын тал зах зээлийн зарчмын дагуу Монгол Улстай идэвхитэйгээр хамтын ажиллагаа явуулах болно. Хэрвээ Монголын тал нөхцөл байдал бүрэлдэхгүй гэж үзвэл бид нар яарх хэрэггүй байна.

Хятад Монгол хоёр нь хөдөлгөөнгүй хөршүүд билээ. Аливаа юмс яаж ч өөрчлөгдөж байсан, Хятад Улс үргэлжлүүлэн Хятад Монголын иж бүрэн стратегийн түншийн харилцаагаа хөгжүүлж, Монголд элэгсэг дотно, үнэнч шударга, үр ашигтай, хүртээмжтэй гэсэн гадаад харилцааны үзэл баримтлалыг авч хэрэгжүүлсээр, хоёр улсын хөгжлийн стратегийн уялдааг эрчимжүүлж, өөрийн хөгжлийн үр өгөөжөө Монгол Улстай хуваахад, чин үнэнч сэтгэлээр Монгол Улсын хөгжилд дэмжлэг тусалцаа үзүүлэн, хоёр улсын ард иргэдийн найрсга харилцаа болон ойголцолыг нэмэгдүүлнэ. Хоёр талын хамтын хичээл зүтгэлээр, Хятад Монголын харилцаа улам бүр сайжирч, илүү сайхан ирээдүйг угтан авна гэдэгтээ итгэлтэй байна. Хятад Монголын хамтын ажиллагаанаас Монголын ард түмнийг аз жаргалтай амьдрахыг чин сэтгэлээсэй хүсэн ерөөж байна.

МЭДЭЭЛЭЛ



Asian Development Bank



УИНА ДЭД ТӨВ

ТЕНДЕРИЙН УРИЛГА (НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ)

Огноо: 2017 оны 07 сарын 03
Зээлийн дугаар ба нэр: Зээл MFF0078/LOAN FI 83.097: "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр"
Гэрээний дугаар ба нэр: BSWR10: Баянхошуу, Сэлбэ дэд төвд усан сан, насос станцын барилга угсралт болон ус хангамжийн шугам хоолой нийлүүлж, суурилуулах ажил
Тендер хүлээн авах эцсийн сунгасан хугацаа: 2017 оны 07 сарын 17-ны өдрийн 15.00 цаг /Улаанбаатарын цагаар/

1. Монгол улс нь Европын хөрөнгө оруулалтын банк (цаашид "ЕХОБ" гэх)-аас "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр-1"-ийг хэрэгжүүлэх зорилгоор зээл авсан бөгөөд энэхүү санхүүжилтийн тодорхой хэсгийг дээр дурдсан гэрээний дүнгээр санхүүжүүлэхэд зарцуулна.
2. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичигт тодорхойлсны дагуу нэг эсхүл хэд хэдэн гэрээний шалгаруулалтад оролцох боломжтой. Нэгээс дээш тооны гэрээ байгуулах эрх олгогдсон тохиолдолд үнийн хөнгөлөлт эдлэх саналтай тендерт оролцогчид энэхүү саналаа Тендер ирүүлэх маягтад уг үнийн хөнгөлөлтүүд нь тусгагдсан нөхцөлд гаргаж болно.
3. Нийслэлийн засаг даргын тамгын газар нь (цаашид "захиалагч" гэх) эрх бүхий тендерт оролцогчдоос "Баянхошуу, Сэлбэ дэд төвд усан сан, насос станцын барилга угсралт болон ус хангамжийн шугам хоолой нийлүүлж, суурилуулах ажил"-ын (цаашид "ажил" гэх) барилгын ажил гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Table with 3 columns: Багцын дугаар, Багцын нэр, Ажлын тодорхойлолт. Contains details for BAQC 1 and BAQC 2.

4. Энэхүү тендер шалгаруулалтыг АХБ-ны дотоодын өрсөлдөөнт нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, нэг үе шаттай явуулна.
5. Зөвхөн доор дурдсан чадварын үндсэн шалгуур үзүүлэлтийг хангасан эрх бүхий тендерт оролцогч энэхүү тендер шалгаруулалтад оролцоно:

Table with 2 columns: Багцын дугаар, Үндсэн шалгуур үзүүлэлт. Contains detailed requirements for BAQC 1 and BAQC 2.

5. Сонирхсон тендерт оролцогч тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг дараах хаягаар авч болно.
Хаяг: Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн Т.Бямбасүрэн
Нийслэлийн засаг захиргааны IV байр, 10-р давхар, 1002 тоот
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу -15, Самбуугийн гудамж, Улаанбаатар хот 15000
Монгол Улс
Утас: +976 75757810
Факс: +976 75757809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn

7. Эрх бүхий тендерт оролцогч тендерийн баримт бичгийг худалдан авахыг хүсвэл:
- BSWR10: Баянхошуу, Баянхошуу, Сэлбэ дэд төвд усан сан, насос станцын барилга угсралт болон ус хангамжийн шугам хоолой нийлүүлж, суурилуулах ажил"-ын тендерийн баримт бичиг авах хүсэлтийг дээр хаягийн дагуу бичгээр ирүүлнэ.
- Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлт гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр доорхи дансаар 200,000 төгрөг болон түүнтэй тэнцэхүйц валютар (85 ам.доллар) худалдан авч болно. Төлбөрийг МУ-ын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй банкаар дамжуулан хийх тохиолдолд Дотоод шилжүүлэг хүснэгт дэх мэдээллийг, гадаад улс орноос шилжүүлэг хийх тохиолдолд Гадаад шилжүүлэг (For Foreign transfers) хүснэгт дэх мэдээллийг ашиглана.

Table with 4 columns: Гадаад шилжүүлэг (For Foreign transfers), Дотоод шилжүүлэг, Account Name, Bank Account No, Bank Name, Bank Address, SWIFT Code, Correspondent bank, SWIFT Code, Account No (USD).

8. Тендерийг дээр дурдсан хаягаар, тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө тендерийн баримт бичигт шаардсан тендерийн баталгааны хамт ирүүлнэ. Тендерийг тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссан даруйд тендерт оролцогчдын төлөөллийг (хэрэв тэд оролцохыг хүсвэл) байлцуулан нээнэ.
9. Тендерийг харьцуулахдаа тендерийн баримт бичигт тусгасан холбогдох заалтын дагуу дотоодын давуу эрх олгох аргачлалыг үл хэрэглэнэ.



European Investment Bank



УИНА ДЭД ТӨВ

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 06 сарын 02
Зээлийн дугаар ба нэр: Зээл MFF0078/LOAN FI 83.097: "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр"
Гэрээний дугаар ба нэр: BSPE: Сэлбэ, Баянхошуу дэд төвд ус хангамж, ариутгах татуургын яндан хоолой нийлүүлэх
Тендер хүлээн авах эцсийн сунгасан хугацаа: 2017 оны 07 сарын 17-ны өдрийн 11.00 цаг /Улаанбаатарын цагаар/

1. Монгол улс нь Европын хөрөнгө оруулалтын банк (цаашид "ЕХОБ" гэх)-аас "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр-1"-ийг хэрэгжүүлэх зорилгоор зээл авсан бөгөөд энэхүү санхүүжилтийн тодорхой хэсгийг дээр дурдсан гэрээ санхүүжүүлэхэд зарцуулна.
2. Нийслэлийн засаг даргын тамгын газар нь (цаашид "захиалагч" гэх) эрх бүхий тендерт оролцогчдоос "Сэлбэ, Баянхошуу дэд төвд ус хангамж, ариутгах татуургын яндан хоолой"-г нийлүүлэх зорилгоор битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.
3. Энэхүү тендер шалгаруулалтыг АХБ-ны дотоодын өрсөлдөөнт нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, нэг үе шаттай явуулна.
4. Зөвхөн доор дурдсан чадварын үндсэн шалгуур үзүүлэлтийг хангасан эрх бүхий тендерт оролцогч энэхүү тендер шалгаруулалтад оролцоно:

- (i) Санал болгосон бараа нь хамгийн багадаа 8 жилийн турш үйлдвэрлэгдэж ирсэн, ба хамгийн багадаа 8 жилийн (2008-2016 онд) турш борлогдсон болон барилга угсралтад амжилттай хэрэглэгдэж, ашиглагдаж ирсэн байна.
(ii) Сүүлийн 3 жилд (2014, 2015, 2016 онд) гүйцэтгэж дууссан эсхүл гүйцэтгэж байгаа гэрээний жилийн дундаж борлуулалтын доод хэмжээ 4.4 тэрбум төгрөг байна.
(iii) Сүүлийн 3 жилд (2014, 2015, 2016 онд) үндсэн гүйцэтгэгчээр амжилттай ажиллаж дуусгасан нэг гэрээтэй байна. Гэрээний үнийн дундаж хэмжээ нь 3.6 тэрбум төгрөгөөс доошгүй байна. Гэрээний агуулаа ба иж бүрдэл нь нэрлэсэн тендертэй ижил байна.
(iv) Гэрээний хэрэгжилтийн явцад шаардлагатай мөнгөн гүйцээний хэрэгцээг хангаж чадах түргэн хөрвөх чадвартай хөрөнгө, авах боломжтой зээл, эсхүл бусад санхүүжилтийн нийт хэмжээ. Шаардлага хангахуйц түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн доод хэмжээ 850.0 сая төгрөг байна.
6. Сонирхсон тендерт оролцогч тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг дараах хаягаар авч болно.

Table with 3 columns: Гадаад шилжүүлэг (For Foreign transfers), Дотоод шилжүүлэг, Account Name, Bank Account No, Bank Name, Bank Address, SWIFT Code, Correspondent bank, SWIFT Code, Account No (USD).

8. Тендерийг дээр дурдсан хаягаар, тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө тендерийн баримт бичигт шаардсан тендерийн баталгааны хамт ирүүлнэ. Тендерийг тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссан даруйд тендерт оролцогчдын төлөөллийг (хэрэв тэд оролцохыг хүсвэл) байлцуулан нээнэ.
9. Тендерийг харьцуулахдаа тендерийн баримт бичигт тусгасан холбогдох заалтын дагуу дотоодын давуу эрх олгох аргачлалыг үл хэрэглэнэ.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдөр
Тендер шалгаруулалтын нэр: "Сургуулийн автобус төслийн хүрээнд бага оврын автобус худалдан авах ажил"
Тендер шалгаруулалтын дугаар: НХААГ-17/0040

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас эрх бүхий тендерт оролцогчдоос "Сургуулийн автобус төслийн хүрээнд бага оврын автобус худалдан авах ажил"-ын нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.
Энэхүү барааны тендер шалгаруулалт нь Цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50 000 (тавин мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.
Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.
Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.
Үүнд:
Борлуулалтын хэмжээ: Сүүлчийн 2 жил /2015, 2016 он/-ийн борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртөгийн 50 %-иас багагүй байна.
Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2015-2016 онуудын аль нэг жилд төсөвт өртөгийн 50%-иас багагүй ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу /2015-2016 он/ 50%-иас багагүй ижил төстэй ажил хийсэн байна.
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Төсөвт өртөгийн 50 %-иас багагүй байна.
Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу /2015-2016 он/
Тендерийн баталгааны үнийн дүн: 4,500,000 (дөрвөн сая таван зуун мянга)төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.
Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилгааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.

Тендерийг 2017 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 08 цаг 00 минутаас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 08 цаг 30 минутад Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын тендерийн нээлтийн өрөөнд нээнэ.
Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй. Дотоодын давуу эрх тооцно.
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, 10 дугаар давхар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Утас: 75757810
Цахим хаяг: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn,

Орчин Угт

Парис Жексон: Пол Маккартниг зориулж дуу бичсэн

Орчуулсан: Б.ДАВААХҮҮ

Попын хаан Майкл Жексоны охин Парис Жексон өнгөрсөн долоо хоногт ирэх сард худалдаанд гарах "Teen Vogue" сэтгүүлд ярилцлага өгчээ. Түүний ярилцлагыг "Оддын цаг" буландаа орчуулан хүргэж байна.

-Парис, чи энэ оныг сэтгүүлийн ковер, улаан хивсний ёслол, урлаг соёлын арга хэмжээ гээд үнэхээр гайхалтай эрч хүчтэйгээр эхлүүлсэн шүү дээ. Надад нэг зүйл сонин байна. Урагш алхах энэ шийдвэрийг та өөрөө гаргав уу, аль эсвэл хэн нэгэн зөвлөсөн үү?

-Үнэнийг хэлэхэд, олон нийтийн анхаарлын төвд байх би дургүй. Энэ намайг айлгадаг байсан. Хүмүүс юу хийж чадахыг би харсан. Тэгээд шархалдаг байлаа. Гэхдээ удаан хугацаанд бодсоны эцэст өөрт ногдсон давуу талаа дэмий үрж суухыг хүсээгүй учраас хүмүүст нөлөөлөх ажлаа эхлүүлсэн. Маш олон хүн нийм төрлийн ажил эрхэлдэг. Тэдний дэргэд миний өчүүхэн жижиг юм даа. Олон хүн өнөөдөр хэн ямар гутал өмссөн, ямар машин унаж, ямар хүрэм өмссөн гэдэгт л анхаардаг болжээ. Харин би өөрийн үзэл санаагаа тэдгээрээс өөр чухал зүйлд зориулахыг хүсч байна. Үнэндээ, өөр зүйл хийхийг хүсч байна. Одоо би жүжиглэж, бас загвар өмсдөг. Цаашдаа өөрийн дуу хоолойгоо хүргэж чадах бүхий л салбарт хүчээ сорино.

-Би чиний инстаграмм хуудсаар зочлох дуртай. Учир нь тэнд байнга


аливаа зүйлийн мөн чанарын тухай постолсон байдаг. Байгаль орчин, шударга ёсны чиглэл дэх таны үзэл бодлыг сонирхмоор байна?

-Баярлалаа. Би жаахан байхаасаа л байгаль орчны асуудал, амьтдад байнга л санаа тавьж ирсэн. Хүүхдэд зориулсан маш олон баримтат нэвтрүүлгийг үздэг байлаа. Аз болоход үүнийг ачаар улсынхаа түүх соёлын талаар сайн боловсрол эзэмшсэн гэж боддог. Хэсэг хугацаанд колончлолын талаар судалж байсан юм. Тэгэхэд колончлолын цаахад шударга бус байдлын талаар уншаад маш их бухимдаж байснаа санаж байна. Харин том болох тусам өнөөгийн нийгэмд шударга бус байдалтай өдөр бүр л нүүр тулж байна шүү дээ. Би энэ бүхний эсрэг ямар нэг зүйл хийхийг хүсч байна.

-Олны анхаарлыг өмнөхөөсөө илүү ихээр татаж эхэлснээс хойш таны амьдралд янз бүрийн л зүйл тохиолдсон байх. Хамгийн сүүлийн жишээ дурьдаач?

-Энэ хорвоогийн аливаа зүйл харагддаг шигээ байдаггүй юм гэдгийг ухаарахтайгаа болсон. Шар хэвлэлд нийтлэгдсэн бүхий л бичвэрүүдийг хар л даа. "Мэдээ" гэсэн атлаа дандаа л олны танил хүмүүсийн талаарх хов жив. Би олны танил хүмүүсийн зөвлон шаналал, оролдлого, худал хуурмагийн талаар мэдээлэх нь буруу юмаа гэдгийг ойлгуулахыг хүсч байна. Бид хамтдаа үүнийг залруулж чадна.

-Сонирхолтой л юм. Чи ч гэсэн олны анхаарлын төвд байдаг учраас хэвлэл мэдээлэлд өөрийн гэсэн сорилттой тулгарч байсан уу?



-Мэдээж. Өмнөхөөсөө илүү их анхаарал татаж, илүү их бай нь болсон. Хүмүүс заримдаа маш хэрцгий болдог. Юу ч хийсэн бай тэд үргэлж доог тохуу мэт хүлээж авдаг гэдгийг би суралцсан. Зүрх сэтгэл минь зөв газраа байгаа цагт, хэн нэгэн намайг үзэн ядсан ч надад хамаагүй. Тэдгээр мэдээлэл тийм ч чухал биш гэдгийг бас суралцсан. Би зөв гэж бодсон зүйлээ л хийж ирсэн. Тэр нь ч зөв байсан.

-Таны хамгийн дуртай дуу?
-Маш олон бий. Магадгүй "Wait for It". Эсвэл "Non-Stop", "My Shot" байх.
-Нэг асуулт асуухгүй бол болохгүй

нь. Та өөрийн гэсэн хөгжмийн карьераа хөөх болоогүй юу?

-Би бичихдээ илүү сайн.
-Таны бичихийг хүсдэг мөрөөдийн хөгжим тань юу вэ?

-Пол Маккартни миний хамгийн хайртай уран бүтээлч. Би аль хэдийн нэг дуу түүнд зориулж бичсэн байгаа.

-Би үүнийг л сонсохыг хүсч байлаа. Уран бүтээл нь хэзээ олон нийтэд хүрэх вэ. Эсвэл нууц юм уу?

-Хэрэв Пол дуулахыг зөвшөөрвөл, чи энэ талаар мэдсэн анхны хүн болох байх. Гэхдээ одоогоор дугаа бичүүлэх талаар төлөвлөсөн зүйл алга байна.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 24
Шөнө 11

Нөгөөдөр
Өдөр 26
Шөнө 11

Өдрийн зурхай

ЗУНЫ ДУНД УЛААН МОРЬ САР ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХАР ЛУУ ӨДӨР

Наран ургах шингэх: 04.59-20.53

Үс засуулбал: Эрхтэн хурц болно



Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд зөвөрсөн сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг луу нөлөөтэй тул элдэв үйлд хяналттай хандаж, биеэ энхрийлүүштэй. Идээ, хувцас хунар олдох, худалдаа найтгаа хийх, эд зүйлс өгөлцөж авах, өглөг өгөх, хөрөнгө цацах, эдийн тэнгэр тахиулах, шид бүтээл үйлдэх, эл засал хийлгэх, авшиг авах, бэрийн үйл, дайсныг дарахад болон хуран чуулах, үс угаахад сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нүд татвал тэмцэл болох, баруун чих хангинавал сайн, зүүн нь хангинавал өчүүхэн нэгнийг үзэх, тагнай загатнах, бие татвал үзэгдэл болох, хөлийн шөрлөс татвал үг, асуулт болно. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой.

ЭРХТЭН СИСТЕМАДЭЭ ИХ ЦӨВӨРЛӨГӨӨ ХИЙГЭЭРЭЙ



АНУ –ын 114 жилийн хөгжилтэй UNICITY компанийн ургамлын гаралтай, цэвэрлэгч тэжээл өгөгч UNICITY CLEANSE бүтээгдэхүүнийг уншигч тань танилцуулж байна. Энэхүү бүтээгдэхүүн нь монголчуудын толгойн өвчин болоод буй өтгөн хатаал болон таргалалтын асуудлыг бүрэн шийдэж, маш сайн үр дүн гаргаад байгаа. Хүний гэдсэнд олон жил хуралдан тогтож чулуужсан 5-40 кг баас шаваадас, 130-аад төрлийн шимэгч үүрлэж байна.

Нэг хүнээс доод тал нь 4-5 төрлийн шимэгч илэрч байгаа нь аюулын харанга дэлдэж байна. Шимэгчийг биеэс гадагшлуулахгүй бол яаж ч жин хассан буцаад жин нэмэгддэг. Шимэгч паразитууд өөрөөсөө хор ялгаруулж хүнийг үхэлд хүргэх аюултай бөгөөд хорт хавдар

үүсэх нэг шалтгаан болж байна. Тиймээс таньд UNICITY CLEANSE цэвэрлэгээний төгс бүтээгдэхүүнийг таньд санал болгоё.

Шимэгч, бактери, хог хаяглаас биенийг цэвэрлэснээр гарах үр дүн:

- Ядрахаа болино
- Хөгшрөлтөөс сэргийлнэ
- Харшилд өртөхгүй
- Өтгөн хатах, гүйлгэх, шамбарам зэргээс ангижирна
- Хэт таргалах, Хэт турах,
- Гэдсээрээ бүдүүрхээс ангижирна
- Дархлаа сайжирч, бактери вирусын халдварт өртөхгүй
- Тууралт загатнаа, батга, хуурайшилт зэрэг арьсны эмгэг засаж, өнгө сайжруулна

- Хоолны шингэц сайжруулна
- Шээс дасагны зовиургүй болно
- Амьсгал биеийн үнэр тааламжтай болно
- Анхаарал төвлөрөл, ой тогтоомж,
- Арьс чангаруулна
- Сэтгэн бодох чадвар сайжирна.
- Архи ,тамхины донтолтгүй болно

Давуу тал: Манай бүтээгдэхүүн нь клиник судалгаа хийж батлагдсан албан ёсны зөвшөөрөл, гэрчилгээтэй 100 хувь ургамлын гаралтай дэлхийд танигдсан бүтээгдэхүүн билээ.

Жич: АНУ-ын соронзон долгионы аппаратаар эрхтэн системийн 37 үзүүлэлт 250 зүйлээр хямд оношилж байна.

Манай хаяг: 25-р эмийн сан Кёкүшю цамхаг 7 давхарт 706 тоот. Утас: 99003733, 88961635. Зөвлөгөө мэдээлэл, хүргэлт үнэгүй.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ АЛБАДАН ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЗАР

Говь-Алтай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас доорх үл хөдлөх эд хөрөнгийн анхны албадан дуудлага худалдааг 2017 оны 07 дугаар 20-ны өдрийн 10:00 цагт зохион байгуулна.

Д/д	Эд хөрөнгийн байршил	Хэмжээ	Зориулалт	Байршил	Харилцан тохиролцож тогтоосон, үнэлгээний тогтоосон үнэ	Дуудах үнэ Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.4-д заасны дагуу харилцан тогтоосон, нэлгээний тогтоосон үнийн 50%	Шийдвэр гүйцэтгэгч
1	Говь-Алтай аймаг Есөнбулаг сумын Жаргалант багийн Сутай хороо 2 дугаар гудамжны 07 тоот хаягт байрлах эзэмших эрхийн улсын бүртгэлийн 0303618 дугаартай гэрчилгээтэй, гэр бүлийн хэрэгцээний газар, улсын бүртгэлийн Y-0518000894 дугаарт бүртгэгдсэн, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн 000121046 дугаар гэрчилгээтэй, орон сууцны зориулалттай хувийн сууц	Газар 330 м2 Хувийн сууц 52 м2	Гэр бүлийн хэрэгцээний газар, хувийн сууц	Говь-Алтай аймаг Есөнбулаг сумын Жаргалант багийн Сутай хороо 2 дугаар гудамжны 07 тоот	17564444	8782222	Ч.Энхтуяа 99927912 89086019
2	Говь-Алтай аймаг Есөнбулаг сумын Харзат баг 13 дугаар байрны 01 тоот хаягт байрлах улсын бүртгэлийн Y-0518000484 дугаартай, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн 000226261 дугаар гэрчилгээтэй, орон сууц	Орон сууц 32м2	Орон сууцны зориулалттай	Говь-Алтай аймаг Есөнбулаг сумын Харзат баг 13 дугаар байрны 01 тоот хаягт байрлах	35629283	17814641	Ч.Энхтуяа 99927912 89086019
3	Говь-Алтай аймаг Есөнбулаг сумын Харзат багт байрлах улсын бүртгэлийн Y-0518000421 дугаартай, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн 000166194 дугаар гэрчилгээтэй агуулах гараж	Агуулах гараж 150м2	Үйлчилгээний зориулалттай агуулах гараж	Говь-Алтай аймаг Есөнбулаг сумын Харзат багт байрлах	30556381	15278190	Ч.Энхтуяа 99927912 89086019

Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Оргил баг Говь-Алтай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны хурлын зааланд болно.
Жич: Дэнчин болох үнийн дүнгийн 10 хувийг 2017 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн 13:00 цаг хүртэл албаны дансанд бэлнээр тушааж, бүртгүүлсэн байна.
Харилцах утас:99927912, 890863108, 89086019